




НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

СОНГУУЛИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

ТОЙМ СУДАЛГАА



Улаанбаатар хот
2024 он

ННА 67
ДАА 340
Э-66

СОНГУУЛИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ ТОЙМ СУДАЛГАА

Судлаач:

Э.Хишигбайгаль, Дотоод хэргийн их сургуулийн багш, докторант
Б.Энхцэцэг Хуульч, өмгөөлөгч

© Нээлттэй Нийгэм Форум, 2024

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар 14240
Утас: 76113207
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

Энэхүү судалгааны дүгнэлт нь уг судлаачдын үзэл бодол, байр суурь бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг төлөөлөхгүй.

ISBN 978-9919-9136-3-2

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй нийгэм форум нь засаглал, хүний эрх, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, хамгаалах чиглэлээр бодлогын судалгаа, нөлөөллийн ажлыг тууштай дэмжин ажиллаж ирсэн билээ. Бид өнгөрсөн жилүүдэд Эрх зүйн хөтөлбөрийнхөө хүрээнд эрүүгийн эрх зүйн чиглэлээр цөөнгүй судалгааг дэмжиж, судалгааны тайланг хэвлэн нийтийн хүртээл болгоод байна. Энэ удаад залуу судлаачид болох Э.Хишигбайгаль, Б.Энхцэцэг нарын 2023 онд гүйцэтгэсэн “Сонгуулийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлт” судалгааны тайланг Та бүхэнд хүргэж байна.

Тус судалгаа нь эрүүгийн хууль тогтоомжоор иргэний улс төрийн суурь эрхийн нэг болох сонгох, сонгогдох эрхийг хамгаалсан байдал, зөрчигдсөн эрхийг сэргээхэд эрх зүйн орчин болон хууль сахиулах, хэрэг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааны үр нөлөөг тоймлон авч үзжээ.

Сонгуулийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх чиглэлээр хийгдсэн судалгаа хомс, холбогдох мэдээллийг олж авах боломж бага, статистик мэдээлэл нарийвчлалтай гардаггүйгээс мэдээлэл цуглуулахтай холбоотой багагүй бэрхшээл, сорилт тулгарсан ч судлаачид маань сонгуулийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн гаралт, түүнийг хянан шийдвэрлэж буй практикийг тоймлон харахад тус дөхөм болохуйц судалгааг гүйцэтгэж олон нийтэд танилцуулж байгаа нь ач холбогдолтой юм.

УИХ-ын ээлжит сонгууль явагдсан жилд энэхүү судалгааны тайланг сонирхох улс төрч, нам, эвсэл, идэвхтэй сонгогчид цөөнгүй бий гэдэгт итгэлтэй байна. Ардчилсан нийгэмд иргэн бүр өөрийн улс төрийн эрхээ баталгаатай, бүрэн эдлэх нь нэн чухал билээ.

*П.Эрдэнэжаргал
Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх Захирал*

АГУУЛГА

| | |
|---|-----------|
| ӨМНӨХ ҮГ | 3 |
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ | 5 |
| ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ | 6 |
| СУДАЛГААНЫ ТОВЧООН | 8 |
| УДИРТГАЛ | 10 |
| НЭГ. СОНГУУЛИЙН ЭРХ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ | 13 |
| 1.1. Сонгуулийн эрх, түүний хэрэгжилт | 13 |
| 1.2. Сонгуулийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин | 17 |
| 1.3. Сонгуулийн эрхийн эрүүгийн эрх зүйн хамгаалалт | 18 |
| ХОЁР. СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ | 26 |
| 2.1. Гэмт хэргийн нөхцөл байдал..... | 26 |
| 2.2. Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүн ба зүйлчлэлийн асуудал | 36 |
| 2.3. Гэмт хэрэгт оногдуулах ял, ялын бодлого | 45 |
| 2.4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практик | 50 |
| 2.5. Гэмт хэргийн шалтгаан нөхцөл..... | 58 |
| ГУРАВ. СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙГ ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ | 60 |
| 3.1. Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн харьцуулалт..... | 61 |
| 3.2. Ялын бодлогын чиглэлээрх харьцуулалт | 62 |
| ДҮГНЭЛТ, САНАЛ | 65 |
| АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ | 70 |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|-----------|--|
| АН | Ардчилсан нам |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс (Өмнөд Солонгос) |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЗГ | Засгийн газар |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| МАН | Монгол Ардын Нам |
| МУИХ | Монгол Улсын их хурал |
| МУҮНХ | Монгол Улсын Үндсэн хууль |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| СЕХ | Сонгуулийн ерөнхий хороо |
| СМБ | Сонгуулийн менежментийн байгууллага |
| УДШ | Улсын дээд шүүх |
| УИХ | Улсын их хурал |
| УТН | Улс төрийн нам |
| УТНТХ | Улс төрийн намын тухай хууль |
| ҮнХ | Үндсэн хууль |
| ҮнХЭЗ | Үндсэн хуулийн эрх зүй |
| ХБНГУ | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс |
| Цахим сан | Шүүхийн шийдвэрийн цахим сан |
| ЦЕГ | Цагдаагийн ерөнхий газар |
| Цэц | Үндсэн хуулийн цэц |
| ШЕЗ | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| ЭХ | Эрүүгийн хууль |
| ЭХТА | Эрүүгийн хуулийн тусгай анги |
| ЭХХША | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа |
| ЭХХШТХ | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль |

ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | | |
|------------|---|----|
| График 1. | Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн тоо: | 27 |
| График 2. | Шүүхээр шийдвэрлэсэн сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн зүйлчлэл | 31 |
| График 3. | Хохирогчдын улс төрийн намын харьяалал | 32 |
| График 4. | Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдогчдын улс төрийн намын харьяалал..... | 33 |
| График 5. | Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдогчийн нас, хүйсийн мэдээлэл..... | 34 |
| График 6. | Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт холбогдогчдын боловсрол, ажил эрхлэлт | 34 |
| Хүснэгт 1. | Бичил асуумжийн судалгаа: Сонгогдох эрхийн хэрэгжилт | 15 |
| Хүснэгт 2. | ЭХ-иуд дах сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн зохицуулалт (2002, 2015 он) | 21 |
| Хүснэгт 3. | Өршөөлд үл хамруулах заалтад багтсан байдал | 24 |
| Хүснэгт 4. | Шүүхээр шийдвэрлэсэн сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн мэдээлэл | 27 |
| Хүснэгт 5. | ЦЕГ: 2016-2022 онд Монгол Улсын ЭХТА-ийн 14 дүгээр бүлгийн холбогдох зүйл ангиар хэрэг үүсгэж шалгасан хэргийн тоо, шүүхэд шилжүүлсэн хэргийн тоо | 28 |
| Хүснэгт 6. | “Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг”-ийг хянан шийдвэрлэсэн мэдээлэл /2018-2021 он/..... | 29 |
| Хүснэгт 7. | 2016-2022 онд Сонгуулийн эрх, эрх чөлөө зөрчсөн гэсэн агуулгатай гомдол хүлээн авч шалгасан тоо..... | 30 |
| Хүснэгт 8. | Цагдаагийн байгууллагаас сонгуулийн эрхийн зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэсэн статистик (хувийн эх сурвалжаас)..... | 30 |
| Хүснэгт 9. | Шүүхээр шийдвэрлэсэн Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн зүйлчлэл | 32 |

| | | |
|-------------|--|----|
| Хүснэгт 10. | Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгтэй төсөөтэй зөрчлүүд | 43 |
| Хүснэгт 11. | Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ялын төрөл..... | 45 |
| Хүснэгт 12. | Ялын зорилго, цээрлэл, хэмжээ | 46 |
| Хүснэгт 13. | Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн ялын бодлогын өөрчлөлт (хорих ял) | 47 |
| Хүснэгт 14. | Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт шүүхээс оногдуулсан ялын төрөл, хэмжээ | 48 |
| Хүснэгт 15. | Шүүхээр шийдвэрлэсэн хэргийн товч мэдээлэл(он цагийн дарааллаар) | 51 |
| Хүснэгт 16. | Төсөөтэй хэргийг шийдвэрлэсэн байдал | 54 |
| Хүснэгт 17. | Сонгогдох эрх зөрчигдсөн талаарх өргөдөл, гомдол гаргагчдын мэдүүлэг | 56 |
| Хүснэгт 18. | Зарим улс орнуудын сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ялын төрөл | 63 |
| Хүснэгт 19. | Сонгуулийн эрх хэрэгжүүлэхэд саад учруулах гэмт хэрэгт оногдуулах хорих болон ялын хэмжээ | 64 |

СУДАЛГААНЫ ТОВЧООН

1. 1992-2022 оныг хүртэлх 30 жилийн хугацаанд УИХ-ын сонгууль 8, Ерөнхийлөгчийн сонгууль 8, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгууль 7, УИХ-ын нөхөн болон дахин сонгууль 11, нийт 34 удаагийн сонгууль болжээ.
2. 2002 онд сонгуулийн эрхийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох зохицуулалт анх ЭХ-д орж, 2008 онд ЭХТА-ийн 130, 131-р зүйл ангиудаар 4 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан нь энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдсэн анхны тохиолдол юм.
3. Харин 2012 онд “сонгогчийн санал худалдаж авсан” хэргийг ЭХТА-ийн 130.2 дах хэсэг “Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх”-ээр зүйлчилж, ял оногдуулсан нь шүүхээр шийдвэрлэсэн анхны хэрэг байв.
4. “Сонгуулийн эрх зөрчигдсөн” агуулгаар ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо сонгуулийн жилүүдэд бусад онуудтай харьцуулахад хэд дахин өсдөг. Тухайлбал, УИХ-ын сонгуулийн жил, 2016 онд - 683, 2020 онд - 1707 байгаа бол, Ерөнхийлөгчийн сонгууль болсон 2017 онд - 168, 2021 онд - 163 бүртгэгдсэн байна. Харин сонгуулийн бус жилүүдэд, жилд дунджаар 17 орчим өргөдөл, гомдол цагдаагийн байгууллагад бүртгэгджээ.
5. ЦЕГ-ын мэдээллээр, 2017 онд 183 өргөдөл гомдлоос 176-г нь буюу 96.2%, 2016 онд 630 өргөдөл, гомдлоос 53-г нь буюу 8.4% хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.
6. 2002-2022.06 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд, сонгуулийн эрхийн эсрэг нийт 10 гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэжээ. Үүнээс 8 хэрэгт ял оногдуулж, 2 хэргийг цагаатгажээ.
7. Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацааг, сонгуулийн хэлбэртэй хамтатган авч үзвэл, 2012 оны УИХ-ын сонгуулийн үеэр 4, 2012 оны орон нутгийн ИТХ-ын

сонгуулийн үеэр 3, 2015, 2018 онд тосгоны захирагчийн сонгуулийн үеэр 2, 2016 оны УИХ-ын сонгуулийн үеэр 1 байна.

8. Дээрх хэргүүдэд 17 этгээд холбогдон шалгагдсаны УТН-ын харьяаллыг тодруулбал, тодорхойгүй - 1, МАН-ын гишүүн - 9, МАН-ын сонгуулийн сурталчилгааны ажилтан - 7 байв.
9. Гэмт хэргийн хохирогчдоос 2 нь өөрт учирсан 2'712'680 төгрөгийн бодит хохирлыг нэхэмжилснээс, шүүхийн шийдвэрийн дагуу 392'800 төгрөгийг хохирогчид төлжээ.
10. Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг нь ихэнхдээ сонгогчийн санал худалдаж авах зорилгоор мөнгө тараах аргаар үйлдэгдсэн байна.
11. Шүүхээр шийдвэрлэсэн сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргүүдийн дийлэнх нь зохион байгуулалттайгаар, бүлэглэн үйлдсэн байна.
12. Шүүхээр ял шийтгүүлсэн 8 гэмт хэргийн 6-д нь торгох ял оногдуулсан ба торгуулийн дундаж хэмжээ нь 10'459'800 (10'000 нэгж) төгрөг байна.
13. Сонгуулийн хугацаа өнгөрмөгц гомдол, мэдээлэл гаргагчийн хэрэг хянан шийдвэрлүүлэх идэвх оролцоо буурах, гомдлоосоо татгалзах нөхцөл үүсэхээс гадна, нэгэнт сонгуулийн үр дүн гарсан бол зөрчигдсөн эрх сэргээх боломжгүй болж, сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэх аль аль талдаа ач холбогдолгүй болдог.
14. 2013-2021 оны Монгол Улсын гэмт хэргийн танилцуулгад ЭХ-ийн 14-р бүлэг, иргэний сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт хамаарах статистик мэдээлэл байхгүй байна. Түүнчлэн энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тухайлсан үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй байна.
15. Сонгуулийн байгууллагаас сонгуулийн тогтолцоо, менежмент зэрэг чиглэлээр бусад улс оронтой туршлага судлах хамтын ажиллагааг өргөжүүлж байгаа ч сонгуулийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хууль тогтоомжийн зохицуулалт, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр туршлага солилцох хамтын ажиллагааны асуудал орхигджээ.

УДИРТГАЛ

Сонгуулийн эрх нь ардчилсан улс орнуудын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан, хүнийг эрх чөлөөтэй, нэр төртэй, үнэ цэнтэй амьдрах суурь нөхцөлийг хадгалж байдаг хүний эрх юм. Иймээс сонгуулийн зорилго, процесс гээд сонгууль бүхэлдээ иргэний эрхийг хэрэгжүүлэхийн төлөө буюу нийгмийн нийтлэг эрх ашгийн төлөө байх ёстой. Мөн иргэний энэ эрх хөндөгдсөн тохиолдолд сэргээх, хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, шударга шүүхээр шүүлгэх асуудал ч мөн сонгуулийн эрхийн хэрэгжилтэд ахиц дэвшил гаргахад чухал ач холбогдолтой. Тухайлбал, сонгуультай холбоотой хэрэг маргааныг ил тод, шударгаар шийдвэрлэх процесс нь сонгуулийн эрхийг хамгаалах арга хэрэгсэл болох тухай олон улсын хүний эрхийн баримт бичгүүд, тэр дундаа Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактад нарийвчлан заасан байна.

Монгол Улсын хувьд сонгуулийн эрхээ шүүхээр хамгаалуулах явдал хангалтгүй байгаа тухай дээрх пактын хэрэгжилт болон Хүний эрхийн төлөв байдлын талаарх хүний эрхийн төрийн бус байгууллагуудаас бэлтгэсэн тайлан илтгэлд¹ дурдсаар иржээ. Жишээ нь, манай улсад аливаа сонгуулийн үеийн маргаанууд нь олон нийтийн анхаарлыг татаж, ярианы сэдэв болдог ч, хуулийн хүрээнд хэрхэн шийдвэрлэгдсэн нь тодорхойгүй байсаар удалгүй мартагддаг. Энэ байдал уламжлал шахуу болж, дараагийн сонгуультай золгож байгаа нь сонгуулийн үр дүн болоод иргэний сонгуулийн эрхийн хэрэгжилт сайжрахгүй байх нэг нөхцөл болж байна. Өөрөөр хэлбэл, иргэний сонгуулийн зөрчигдсөн эрх сэргээгдсэн эсэх асуудал, үүнд хамаарах гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтэд төдийлөн анхаарахгүй байгаа нь сонгуулиас сонгуульд иргэний сонгуулийн оролцоо буурч, эсрэгээр сонгуулийн үр дүнг эсэргүүцэх хандлагыг нэмэгдүүлж байна. Иргэний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд анхаарахгүй, хэрэгжилтийг сайжруулахад ахиц дэвшил гаргахгүйгээр шударга сонгуулийн үр дүнг хүлээх болоод шаардах боломжгүй.

¹ <https://www.upr-mongolia.mn/index.php>

Сонгуулийн үеийн хэрэг маргааныг хэрхэн шийдвэрлэсэн, эсвэл шийдвэрлээгүй талаар мэдээлэл олон нийтэд хүрдэггүй бөгөөд үүнтэй холбоотой албан ёсны статистик, мэдээлэл байхгүй байна. Энэ нь сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг гарч байгаа юу, эсвэл гэмт хэрэг үйлдэгдэхгүй байна уу, энэ төрлийн гэмт хэргийн статистик тоо баримтыг нууцалж байна уу гэх асуултууд урган гарахад хүрч байна. Манай улсад, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь ихэвчлэн нийгмийн анхаарлыг татсан, хүнд гэмт хэргүүд рүү төвлөрдөг ба сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой нэрлэх үйл ажиллагаа байхгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн гаралт төрөөс нэгдсэн бодлогоор анхаарах шаардлагагүй хэмжээнд бага гардаг гэж таамаглахад хүргэсэн болно. Гэвч сонгогчдод мөнгө, бэлэг тараасан үйлдэл олны анхаарлыг татаж, мөн “60 тэрбумын хэрэг” гэх мэт сонгуулийн үеэр ил болсон баримт, нотолгоотой хэргүүд хэрхэн шийдвэрлэгдсэн нь тодорхойгүй, олны дунд яригдсаар байна.

Иймд, энэ судалгаагаар иргэний сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн албан ёсны тоо баримт, эрүүгийн холбогдох бодлого, хууль тогтоомжийн хөгжил, түүний хэрэгжилт ямар байсан, одоо ямар байгаа болоод энэ нь сонгуулийн үр дүнд ямар нөлөө үзүүлэх эсэх, цаашид сайжруулах шаардлагатай бодлого зохицуулалт юу байх талаар асуудал хөндөхийг зорьсон.

Судалгааны хүрээнд, сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлтийн статистик, гэмт хэрэг, шалган шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтэд төвлөрч судаллаа. Ижил сэдвээр хийгдсэн судалгаа, бүтээл ховрын зэрэгцээ эрүүгийн хууль тогтоомж дах гэмт хэргийн зохицуулалтын талаар санал, шүүмж зэргээр асуудал дэвшүүлсэн бүтээл мөн байсангүй. Түүнчлэн энэ төрлийн гэмт хэргийн холбогдох статистик бага байгаа нь хууль хэрэглээний асуудлаар болон хуулийн зохицуулалтын талаар харьцуулалт, дүн шинжилгээ хийхэд хүндрэл учруулж байлаа.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж ажилласан.

- 1) Сонгуулийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх;
- 2) Сонгуулийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн хуулийн зохицуулалтын хэрэгжилт, хэргийн шүүхээр шийдвэрлэж буй практикийг судлах;
- 3) Зарим орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж, сайжруулах санал тодорхойлох;
- 4) Гэмт хэргийн шийдвэрлэлтийг сайжруулахад нөлөөлөх санал боловсруулах;

Судалгаанд дараах аргуудыг сонгон авч ажиллалаа. Үүнд:

- 1) Баримт бичгийн судалгаа: Төрөөс баримтлах бодлого, эрх зүйн зохицуулалтын хөгжил, нөхцөл байдлыг тодруулах;
- 2) Тоон мэдээллийн шинжилгээ: Энэ төрлийн гэмт хэргийн статистик, баримт, мэдээлэл цуглуулж шинжлэн судлах;
- 3) Харьцуулалт: Эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдлийг илрүүлэх болон зарим улс орны эрх зүйн зохицуулалтаас ялгаатай байдлыг тодруулах;
- 4) Шүүхийн шийдвэрийн шинжилгээ: 2002 оноос хойших шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийг түүвэрлэн авч, түүний шийдвэрт дүн шинжилгээ хийх;
- 5) Асуулга, ярилцлага: Эрх зүйн зохицуулалт болон эрүүгийн хэрэг шийдвэрлэлтийн нөхцөл байдлыг тодруулах;

Дээрх аргуудаар гэмт хэргийн шийдвэрлэлтийн нөхцөл байдал болон анхаарвал зохих асуудлуудыг тодорхойлж, цаашид сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлтийг сайжруулахад нөлөөлөх бодлогын саналууд дэвшүүлснийг тайлангийн сүүлийн бүлгээс дэлгэрүүлж харна уу.

Цаашид, энэ төрлийн гэмт хэргийн гаралтад нөлөөлж буй сонгуулийн тогтолцооны асуудал болон сонгогчдын эрх, эрхийн зөрчил, түүний эрх зүйн хамгаалалтын талаарх мэдлэг, хандлагыг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай нь судалгааны явцад ажиглагдлаа. Тухайлбал, өнөөгийн сонгуулийн тогтолцоо нь улс төрийн жижиг намууд болон бие даан нэр дэвшигчдэд хууль хэрэглээний хязгаарлалт бий болгож, эсрэгээр эрх баригч том намуудад хууль тогтоомж зөрчих, зөрчсөн ч хариуцлагаас зайлсхийх боломж бий болгож байгаа эсэх, энэ нь иргэд, сонгогчдын гэмт хэрэг, зөрчлийг хүлээн зөвшөөрөх хандлага болон сонгуулийн идэвх, оролцоонд хэрхэн нөлөөлж буйг судлах хэрэгцээ шаардлага байгааг дурдах нь зүйтэй. Сонгуулийн эрхийн эрх зүйн хамгаалалтын асуудалд улс төрийн намын дотоод, гадаад бодлого, зохицуулалтын эерэг, сөрөг нөлөөллийг анхаарч судлах нь иргэдийн сонгуулийн эрхийн хэрэгжилт болон сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлтийг сайжруулахад чухал ач холбогдолтой.

НЭГ. СОНГУУЛИЙН ЭРХ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ

1.1. Сонгуулийн эрх, түүний хэрэгжилт

Сонгуулийн эрх нь иргэний улс төрийн эрх бөгөөд олон улсын хүний эрхийн тунхаглал, гэрээ конвенцод² тусгагдаж, тухайн гэрээ, конвенцод нэгдэн орсон улс орны үндэсний хууль тогтоомжоор баталгаажин, чөлөөтэйгөөр, шууд сонгогдсон төлөөлөөр дамжуулан төрийн эрх барих улс төрийн эрхийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг. МУҮНХ-ийн 16 дугаар зүйлийн 9-д *“Монгол Улсын иргэн нь шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй...”* хэмээн иргэний сонгуулийн эрхийг баталгаажуулсан.

Эрх зүйн зохицуулалт дах нийтлэг ойлголтоор, иргэний сонгох болон сонгогдох эрх нь сонгуулийн эрхэд хамаарна. Харин хүний эрхийн зарим баримт бичигт сонгуулийн эрхийг сонгох, сонгогдох эрхээр хязгаарлахгүйгээр сонгуульд оролцох зорилгоор эвлэлдэн нэгдэх, шууд болон төлөөлөгчийн байгууллагаараа дамжуулан төрийн үйл хэрэгт оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, гомдол гаргах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, эрхээ хамгаалуулах хэмээн өргөн утгаар нь ойлгож, эрхийн хамгаалалтыг хууль тогтоомжоор бий болгох шаардлагатай талаар дурдсан байдаг. Ингэж сонгуулийн эрхийг өргөн хүрээнд авч үзэн, эрх зүйн хамгаалалтыг бий болгох нь сонгуулийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх баталгаа болж сонгуульд оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, шударга сонгуулийн үр дүнд нөлөөлөх ач холбогдолтой гэж үздэг байна.

Сонгох эрх: Холбогдох хуульд зааснаар, сонгогч нь МУ-ын иргэн байх, 18 насанд хүрсэн байх суурь нөхцөлийг тавьдаг. Иргэн бүр энэ эрхээ биечлэн эдлэх эрхтэй боловч зөвхөн сонгогч болсноор санал өгөх эрхтэй болох

² Хүний эрхийн түгээмэл тунхаглал 20,21 дүгээр зүйл; Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын конвенц; Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах конвенц;

хязгаарлалтыг сонгуулийн холбогдох хуулиудад заажээ. Өөрөөр хэлбэл, сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн байх шаардлагатай бөгөөд нэрийн жагсаалтад бүртгэгдсэнээр сонгогчийн үнэмлэх авах нөхцөл бүрддэг. Иргэдийн хувьд сонгох эрхээ хэрэгжүүлэх тухайд тэр бүр асуудал үүсдэггүй мэт боловч дараах нөхцөл байдал цөөнгүй ажиглагддаг. Үүнд:

- Хуулиар хориглоогүй ч гадаадад амьдарч буй, шилжин суурьшсан, хаягийн бүртгэл өөр, оюутнууд, цагдан хоригдсон, цэрэг, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг иргэд нь өөрийн хүсэл зоригоос хамаарахгүйгээс санал өгөх боломжгүй.
- Мөнгө, эд зүйлс тараах эсвэл мөнгө өгнө гэж амлах, аль нэг намд санал өгүүлэх гэж хүмүүсийг ятгах, сонгогчдыг угтан авч нөлөөлөх зэрэг зөрчил³ хамаарна.

Эдгээр нь сонгууль бүх нийтийн байх, сонгогч саналаа нууцаар гаргах, хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж саналаа өгөх боломжгүй болгох зэргээр иргэний сонгох эрхийн зөрчил болдог.

Мөн “нэр дэвшүүлэх эрх” буюу саналын хуудсан дээр хэний нэр байхыг сонгох эрхийн асуудал манай улсад төдийлөн хөндөгддөггүй. Өнөөг хүртэлх сонгуулийн түүхэнд “нэр дэвшүүлэх процесс”-т сонгогчид оролцсон практик ховор байна.

Сонгогдох эрх: Сонгогдох эрхийн хэрэгжилт, тулгамдаж буй бэрхшээлийг тодруулах зорилгоор шат, шатны сонгуульд нэр дэвшиж байсан 100 гаруй иргэнд цахимаар асуулга авахаар хандсан боловч ердөө 12 нь асуулгад оролцсон байна.

Асуумжид, 1990-2020 оны хооронд УИХ-ын болон бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэр дэвшиж байсан МАН - 8, АН - 1, Иргэний Хөдөлгөөний нам - 1, Бие даагч - 2, нийт 12 нэр дэвшигч хамрагдсан байна. Эдгээрээс УИХ-ын сонгуульд 8 буюу 50% нь, 8 буюу үлдсэн 50% бүх шатны ИТХ-д нэр дэвшиж оролцсон байна. Хэдий тооны хувьд цөөн хүн хамрагдсан боловч бидний таамаглалыг дэмжих нөхцөлүүд ажиглагдлаа.

³ М.Эрдэнэбаяр, Д.Мягмарцэрэн, Г.Бямбадорж Я.Цэлмэн, Д.Сумъяацэрэн, Э.Золбоо Монгол Улсад сонгууль зохион явуулахтай холбоотой гардаг гэмт хэрэг, зөрчлийг шалгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гарын авлага, УБ., 2016, 7 дахь тал;

ХҮСНЭГТ 1. БИЧИЛ АСУУМЖИЙН СУДАЛГАА: СОНГОГДОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

| № | Асуулт | Хариулт |
|---|--|---|
| 1. | Таны оролцож байсан сонгуулийн үеэр сонгуулийн эрхийн эсрэг ямар хэрэг хэрэг, зөрчил зонхилон гарч байсан бэ? | Худал мэдээлэл тараах; |
| | | Гүтгэх; |
| | | Санал худалдаж авах; |
| | | Жижиг нам, бие даагч нарт боломжийг хаах; |
| | | Мөнгө тараах, худал ухуулга, худал амлалт, мэдээллийн хэрэгслээр нэгэн жигд тэгш оролцоо байхгүй, мэдээллийн хэрэгслүүд зөвхөн мөнгөтэй нам, хувь хүмүүст үйлчилдэг, иргэдтэй уулзах байр талбай зориуд өгөхгүй байх; |
| | | Мөнгө тараах, мотоцикл тараах, малчдад архийг авдраар нь тарааж, найр наадам зохион байгуулах; |
| | | Тухайн үед одоогийнх шиг зөрчил гардаггүй байсан; |
| | | Сонгуулийн хорооны дарга тогтоолоо гаргахдаа миний авсан саналын тоог өөр хүний саналтай санаатайгаар сольж явуулсан (2 хэсгийн хороонд) |
| | | Гараагүй |
| | | Гүтгэх, гутаан доромжлох, сонгогчдод мөнгө тараах |
| | | Санахгүй байна |
| Эмэгтэй нэр дэвшигчдийн эрхийг зөрчих тохиолдол олон гардаг. Мөнгөтэй, мөнгөгүйгээр нь ялгаварлан гадуурхдаг. | | |
| | Хүч хэрэглэх, үндэслэлгүй гүтгэх. | |
| 2. | Сонгуульд нэр дэвших үед бусад нэр дэвшигчдээс таны эсрэг хууль зөрчсөн үйлдэл гаргаж байсан уу? | Тийм 66,7% |
| | | Үгүй 33,3% |
| 3. | Та энэ талаар цагдаагийн байгууллагад өргөдөл, гомдол гаргасан уу? | Тийм 33,3% Үгүй 66,7% |

| | | |
|----|---|---|
| 4. | Таны өргөдөл, гомдол хэрхэн шийдвэрлэгдсэн бэ? Шударга шийдвэрлэгдсэн байдалд та өөрийн дүгнэлтийг өгнө үү. | <p>Өргөдөл өгч байгаагүй;</p> <p>Шалгаж байна гэдэг, эргэж хариу өгдөггүй;</p> <p>Өргөдөл гаргаагүй;</p> <p>Шийдвэрлэгдээгүй, бүртгээд л өнгөрсөн;</p> <p>Шударга шийдэхгүй нь тодорхой харагдсан;</p> <p>Өргөдөл гаргаагүй;</p> <p>Өргөдөл, гомдол гаргаагүй;</p> <p>Шударга шийдвэр гаргаагүй;</p> <p>Гомдол гаргаагүй;</p> <p>Монголд богино хугацаанд асуудал(сонгуулийн зөрчил) шийдвэрлэх боломжгүй. Бүгдийг худалдаж авсан байдаг.</p> <p>Хариу өгөөгүй;</p> <p>Тийм зүйл байхгүй.</p> |
| 5. | Та өөрийн оролцсон сонгуулийн үр дүнг санал нэгдэж хүлээн зөвшөөрсөн үү? | <p>Тийм – 50%</p> <p>Үгүй – 50%</p> |
| 6. | Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлт муу байгаа нь ямар сөрөг үр дагавартай гэж та бодож байна вэ? | <ol style="list-style-type: none"> 1. Хувийн, намын ашиг сонирхол газар авна. 2. Сонгуулийн дүн үнэн зөв гарахад сөрөг нөлөөтэй, 3. Шударга бус байдал газар авах, улсын хөгжил саарах, авлига газар авах, төрийн алба төрлийн хэлхээсээр баяжих, цүнх баригчид болон ижил сонирхолтой хүмүүс албан тушаалтай болдог буруу аргад татагдаж байна. 4. Эрх барьж байгаа нам шүүх, цагдааг эрхэндээ оруулсан 5. Шударга сонгууль явуулахад саад учирна. 6. Хээл хахууль цэцэглэж, чадваргүй мэдлэггүй хүмүүс төрийн эрх авч, улс орон дампуурна. Үндэсний тусгаар тогтнол алдагдаж, ядуурал ихэснэ. Мөнгөөр асуудал шийдвэрлэдэг гаж тогтолцоо аль эрт бий болсон. Сонгуулийн эрхийн эсрэг их олон гэмт хэрэг гарсан ч шийдэж, гэм бурууг тооцсон тухай сонсоогүй. 7. Нийгэмд итгэх итгэл байхгүй болно. 8. Зөрчил давтагдах, нэр дэвшигчид, намууд сонгогчдыг хуурах, сонгууль шударга бус болж үл итгэх байдал ихсэх 9. Ийм байх ёстой/хууль хэрэгждэггүй/ гэсэн ойлголт нийгэмд бат бэх оршиж бусад сөрөг үр дагавруудыг бий болгож байна. Ёс зүйн хариуцлага ер байдаггүй. 10. Улс төрийн тогтворгүй байдал үүсэж, төрд итгэх иргэдийн итгэл буурч байна. 11. Шударга сонгуульд явуулахад сөргөөр нөлөөлж байна. |

Дээрх бичил асуумжийн үр дүнгээс харахад, сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд, УТН-ын дотоод ардчилал, авлигын асуудал; уралдааны хэлбэртэй болсон сонгуулийг дэмжсэн сонгуулийн тогтолцоо, хууль тогтоомжийн зарим асуудлууд зэрэг саад бэрхшээл, хязгаарлалт нэлээдгүй байдгаас гадна эрх нь зөрчигдсөн тохиолдолд эрхээ сэргээлгэх боломжгүй гэсэн байр суурьтай байна.

Сонгогдох эрхийн зонхилон гардаг зөрчил маргаанд, сонгогчдын нэрсийн жагсаалтыг хууль бусаар үйлдсэн, эсвэл сонгогчийг хууль бусаар хассан, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан, санал худлаа тоолсон, сонгуулийн ухуулга, сурталчилгаа хийхэд саад учруулсан, нэр хүндийг унагаасан зэрэг зөрчлүүд⁴ түгээмэл байна.

1.2 Сонгуулийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин

Сонгуулийн эрхийн эрх зүйн хамгаалалт нь МУ-ын нутаг дэвсгэрт иргэний сонгох, сонгогдох болон эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд хамаарах бусад эрхийг хангахад чиглэнэ. МУҮнХ-ийн 16 дугаар зүйлийн 16.14-д, *“МУ-ын хууль, ОУ-ын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...”* гэж заасан нь иргэний сонгуулийн эрхийн эрх зүйн хамгаалалтын үндэс болно.

Эрх зүйн системийн хамгаалах чиг үүргийн дагуу сонгуулийн эрхийн эрх зүйн хамгаалалтын дараах тогтолцоо байна. Үүнд:

1. Үндсэн хуулийн эрх зүйн хамгаалалт
2. Эрүүгийн эрх зүйн хамгаалалт
3. Захиргааны эрх зүйн хамгаалалт
4. Иргэний эрх зүйн хамгаалалт

Энэ дагуу иргэний сонгуулийн эрхийг хэрэгжүүлэх хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын асуудлыг авч үзвэл:

⁴ М.Эрдэнэбаяр, Д.Мягмарцэрэн, Г.Бямбадорж Я.Цэлмэн, Д.Сумъяацэрэн, Э.Золбоо Монгол Улсад сонгууль зохион явуулахтай холбоотой гардаг гэмт хэрэг, зөрчлийг шалгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гарын авлага, УБ., 2016, 7 дахь тал;

1. Эрүүгийн хариуцлага
2. Зөрчлийн хариуцлага
3. Иргэний хариуцлага
4. Сонгуулийн хариуцлага⁵ байна.

Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнөөс үүссэн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг сонгуулийн холбогдох хууль тогтоомжуудад зохицуулсан. Уг зохицуулалтын дагуу, сонгуулийн процессын үе шат бүрд, сонгуулийн эрхийн зөрчилтэй холбоотой хэрэг, маргааныг сонгуулийн зохион байгуулалтыг хариуцаж буй албан тушаалтнаас эхлээд Цэц хүртэл хандан шийдвэрлүүлэх боломжтой байдаг. Тухайлбал, Цэц нь ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу ҮнХ-д нийцээгүй, харшилсан, эсрэг гарсан хууль тогтоомж нь иргэний сонгуулийн эрх, эрх чөлөөг зөрчсөн эсэх асуудлаар хяналт тавьж, дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага байдаг.

Харин сонгуулийн хэрэг, зөрчлийн талаар гомдол, мэдээллийг иргэн, хуулийн этгээд нь цагдаагийн аль ч байгууллагад гаргаж болох ба ингэснээр сонгуулийн эрх зөрчсөн үйлдлийг эрүүгийн эрх зүйн хүрээнд шалгаж шийдвэрлэх нөхцөл болно.

1.3 Сонгуулийн эрхийн эрүүгийн эрх зүйн хамгаалалт

Монгол Улс нь Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогыг тодорхойлж, салбар хуулиудад гэмт хэрэгтэй тэмцэх төрийн үүргийг нарийвчлан тусгаж зохицуулсан байдаг. Энэ хүрээнд сонгуулийн эрх, эрх чөлөөг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдлыг зөрчил, гэмт хэрэгт тооцож, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх асуудал нь Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль зэрэг хууль тогтоомжоор сэргээн эдлүүлэх хууль эрх зүйн орчныг бий болгоод байна.

Сонгуулийн эрхийн эрүүгийн эрх зүйн хамгаалалт нь МУ-ын ҮнХ-иар баталгаажсан иргэний сонгох, сонгогдох эрхийг бүхэлд нь хамгаалах буюу

⁵ Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь, судалгааны тайлан, УБ., 2014, 11 дэх тал;

өргөн утгаараа иргэний ардчилсан нийгмийг хамгаалах тухай юм. Үүнийг ЭХ-ийн зорилгод “Энэ хуулийн зорилго нь МУ-ын ҮнХ-иар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино”⁶ гэж тодруулжээ.

Эрүүгийн эрх зүйн хамгаалалт гэдэгт МУ-ын эрүүгийн хууль тогтоомжид сонгуулийн эрхийг зөрчсөн ямар үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохоор заасан болон тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариуцлага тооцох явдал хамаарна. 2002 оны Эрүүгийн хуулиар, анх удаа сонгуулийн эрхийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох 2 зүйл анги⁷ орсон. Харин 2015 оны шинэ Эрүүгийн хуулийн 14-р бүлэгт, Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгт, сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийг багтааж, өмнөх хуулийн зохицуулалтуудад хэд хэдэн өөрчлөлтүүд оруулжээ. 2002 оны ЭХ-д нийт 13 удаа нэмэлт, өөрчлөлт орж байснаас ЭХТА-ийн холбогдох зохицуулалтуудад доор дурдсан хоёр нэмэлт, өөрчлөлт орж байжээ. Үүнд:

1. 2007 он ЭХТА 131-р зүйл: Гэмт хэргийн субъектэд хорооны даргыг нэмсэн. Сонгуулийн санал хураалтын дүнг зориуд буруу гаргасан үйлдэлд “УИХ-ын тухай хуулийн 50.3⁸-т заасныг ноцтой зөрчиж” нөхцөл зааж хүрээг хумих, мөн хуулийн 57.4⁹-т заасныг ноцтой зөрчиж буруу шийдвэрлэсэн гэсэн шинэ үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор нэмсэн.
2. 2011 онд дараах өөрчлөлтийг оруулсан. Үүнд:
 - 82-р зүйлд 821 заалт нэмэгдэж, төрийн эрх мэдэл авах хуйвалдаан зохион байгуулах гэмт хэргээс сонгуулийн аргаар төрийн эрх мэдлийг авах үйлдлийг салгаж, хорих ялын хэмжээг 10 хүртэлх жилээр багасгасан.
 - 130-р зүйлийн 2 дах хэсэгт, эрх хасах нэмэлт ялыг нэмсэн.
 - 130-р зүйлд 1301 заалт нэмж, Сонгууль болон ард нийтийн санал асуулгад хууль бусаар нэмэлт илүү санал өгөх үйлдлийг хуульчилсан.

⁶ <https://legalinfo.mn/mn/detail/11634>

⁷ 130 дугаар зүйл. Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх, 131 дүгээр зүйл. Сонгуулийн болон бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах

⁸ МУИХ-ын Сонгуулийн тухай хууль, УБ., 2015, 50.3 дах хэсэг: Тойргийн хороо нэр дэвшигчдийг авсан саналын нь тоогоор дараалалд оруулах бөгөөд хамгийн олон, гэхдээ сонгогчдын 25, түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг УИХ-ын гишүүнээр сонгогдсонд тооцно.

⁹ Дээрх хууль, 57.4 дэх хэсэг: Энэ хуульд заасан зөрчил гаргасан сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг түүний бүрэлдэхүүнээс гаргах асуудлыг тухайн шатны сонгуулийн хороо бүрэлдэхүүнээрээ хэлэлцэж шийдвэрлэнэ.

- 131-р зүйлд эрх хасах нэмэгдэл ялын зохицуулалтыг оруулсан.

Эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь, хууль хэрэглээнд ахиц дэвшил гарсан үр нөлөө байсан эсэх нь гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтээс харагдах боловч тухайн өөрчлөгдсөн зохицуулалтыг хэрэг шийдвэрлэх практикт ашигласан тохиолдол байхгүй байна.

1.3.1 Шинэ Эрүүгийн хуулийн зохицуулалт

2015 оны ЭХ-ийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалд, ардчилсан нийгмийн харилцаанд тохирсон, МУ-ын ҮнХ-иар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батална¹⁰ гэжээ.

Энэ хуульд сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийг иргэний сонгох, сонгогдох, бүх нийтийн санал асуулгад оролцох эрхэд халдсан Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүүний цогц бүрдэл¹¹ юм гэж тодорхойлжээ. ЭХТА-ийн 14 дүгээр бүлгийн 14.5-14.9 дэх хэсгийн зохицуулалтууд сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт хамаарна. Үүнд:

- 14.5 дугаар зүйл. Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх;
- 14.6 дугаар зүйл. Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх;
- 14.7 дугаар зүйл. Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах;
- 14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах;
- 14.9 Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах зэрэг байна.

Дээрх зохицуулалтыг 2002 оны ЭХ-ийн зохицуулалттай харьцуулан үзвэл, анзаарагдах ялгаа байхгүй мэт боловч нэр томьёо болон агуулгын хувьд дараах хэд хэдэн өөрчлөлтүүд байна.

¹⁰ <http://criminalman.blogspot.com/>

¹¹ С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй, УБ., 2011, 334 дэх тал;

**ХҮСНЭГТ 2. ЭХ-ИУД ДАХ СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН
ЗОХИЦУУЛАЛТ (2002, 2015 ОН)**

| Эрүүгийн хууль 2002 он | | Эрүүгийн хууль 2017 он | |
|--|--|---|---|
| Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг /зарим/ | | Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг | |
| 130 | Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх | 14.5 | Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх |
| 130 ¹ | Сонгууль болон ард нийтийн санал асуулгад хууль бусаар илүү санал өгөх | 14.6 | Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх |
| 131 | Сонгуулийн болон бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах | 14.7 | Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах |
| 111 | Гүтгэх | 14.8 | Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах |
| 82 ¹ | Сонгуулийг будлиантуулж төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах | 14.9 | Сонгууль хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах |

Шинэ ЭХ-иар орсон онцлох өөрчлөлтүүдийг тодруулбал:

1. Өмнөх хуулиар гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж 4 ангилдаг байсан нь шинэ ЭХ-иар зөвхөн хөнгөн, хүнд гэж 2 ангилал болсон. Ингэснээр, сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргүүд нь хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэргийн ангилалд хамаарч байсан нь өөрчлөгдөж, 5 гэмт хэргийн ердөө 1 нь буюу Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах (ЭХТА 14.9) хүнд, бусад 4 гэмт хэрэг нь хөнгөн гэмт хэргийн ангилалд хамаарч байна.
2. Өмнө нь байсан ялын төрлөөс эд хөрөнгө хураах, баривчлах, цаазаар авах ялыг хасаж, зорчих эрхийг хязгаарлах ялыг нэмсэн. Эрх хасах ял нь үндсэн ба нэмэгдэл ялын чанартай, эд хөрөнгө хураах ял нь нэмэгдэл ялын чанартай байсныг эрх хасах ял нь зөвхөн нэмэгдэл ялын чанартай болгожээ. Ингэхдээ өмнөх хуулийн сонгуулийн эрхийн эсрэг 130, 131 дүгээр зүйл ангид заасан гэмт хэрэгт эрх хасах ялыг үндсэн ялын чанартай оногдуулах зохицуулалттай байсныг болиулж, зөвхөн ЭХТА-ийн 14.8-д заасан Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэмт хэрэгт эрх хасах нэмэгдэл ялыг оногдуулахаар заасан байна. Мөн баривчлах ялыг хасаж, баривчлах ялтай хэргүүдэд хорих болон зорчих эрх хязгаарлах ял оногдуулах зохицуулалттай болжээ.

3. Торгох ялыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр хэмжиж байсныг шинэ хуулиар нэгжийн зохицуулалттай болгосон бөгөөд энэ нь төгрөгийн ханшны уналт, ялын бодлоготой уялдуулж нэг бол ойр ойрхон хуульд өөрчлөлт оруулах, эсвэл энэ нь ялтанд эдийн засгийн хувьд дарамт учруулах ялын бодлогын нөлөөг бууруулах зорилготой. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт анх ял оногдуулсан 2012 онд 140'400 төгрөг байсан бол өнөөдөр 550'000¹² төгрөг байна. Харин төгрөгийн ханш ам.доллартой харьцуулснаар, 2017 онд 2440,6 төгрөг, 2023 оны I сарын байдлаар 3444,60 төгрөг¹³ байна.
4. Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх (ЭХТА 14.5) гэмт хэрэгт торгох, баривчлах ял оногдуулахаар байсныг торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрх хязгаарлах ял оногдуулахаар, хүндрүүлэх бүрэлдэхүүнд эрх хасах, торгох, баривчлах ял оногдуулах байсныг торгох, зорчих эрх хязгаарлах, хорих ял оногдуулахаар болгож өөрчилжээ.
 - Сонгууль болон ард нийтийн санал асуулгад хууль бусаар илүү санал өгөх (2002 оны ЭХ 130.1) гэмт хэргийн зохицуулалтаас “Хууль бусаар” гэснийг хасаж, Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх (ЭХТА 14.6) гэж, “санаатайгаар зохион байгуулсан” гэснээс санаатайгаар гэсэн нөхцөлийг хасаж, сонгуулийн саналын хуудас, ард нийтийн санал асуулгын хуудсыг хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, тээвэрлэсэн, ашигласан үйлдлийг хүндрүүлэх бүрэлдэхүүнээр нэмж хуульчилсан байна. Түүнчлэн зөвхөн баривчлах ял оногдуулахаар байсныг торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрх хязгаарлах ял оногдуулахаар өөрчилж, хүндрүүлэх бүрэлдэхүүнд хорих ял оногдуулахаар болжээ.
5. Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах (2002 оны ЭХ 131) гэмт хэргийн зохицуулалтад дараах өөрчлөлтийг оруулжээ. Үүнд:
 - Сонгуулийн болон бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах гэсний “санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх” зохицуулалтыг хасаж “хууль бусаар нөлөөлөх”¹⁴ гэж,

¹² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=566>

¹³ <https://www.mongolbank.mn/mn/currency-rate>

¹⁴ Хууль бусаар нөлөөлөх тодорхой үйлдлүүдэд: улс төрийн нам, намуудын эвслийн эсрэг сурталчилгаа явуулсан; сонгогчийн санал өгөх, санал хураах, тоолох ажилд зориуд саад хийсэн; бусдыг төлөөлж санал өгөх, саналын хайрцгийн лац, битүүмжлэлийг зориуд гэмтээх, гарын үсэг хуурамчаар үйлдэх, саналын хуудас солих, хүчингүй саналын хуудсаар санал авахыг зохион байгуулсан; хатгасан; дэмжсэнийг ойлгоно.

- Санал хураалтын дүнг буруу гаргах үйлдлийг “УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 50.3-т заасныг ноцтой зөрчиж” гэж тодорхой нөхцөл заасан байсныг хасаж “санал хураалтын дүнг өөрчилсөн” гэж,
 - Оногдуулах ялын тухайд, өмнөх эрх хасах ялыг хасаж, торгох, зорчих эрх хязгаарлах, хорих ял оногдуулах өөрчлөлтүүд хамаарна.
6. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах (ЭХТА 14.8)-ыг гэмт хэрэгт тооцох
7. “Сонгуулийг будилаантуулж төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах” гэмт хэрэг 2002 оны ЭХ-ийн Үндэсний Аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг бүлэгт хамаарч байсныг, Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах (ЭХТА 14.9) хэмээн томьёолж оруулсан. Энэ хүрээнд дараах өөрчлөлт хамаарч байна:
- Өмнөх хуулиар гэмт хэргийн субъектив шинжийг “сонгуулийг будилаантуулах нь төрийн эрх мэдлийг хууль бусаар авах санаа, зорилготой” гэж тодорхойлсныг “Сонгуулийг хууль бусаар явуулах” зорилготой болгон өөрчилсөн.
 - Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив шинжийг “сонгуулийг зохион байгуулалттайгаар будилаантуулсан” гэснийг сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх зорилгоор сонгуулийн эрхийн эсрэг энэ хуульд заасан гэмт хэргүүдийг¹⁵ үйлдэхээр бэлтгэсэн, зохион байгуулсныг гэмт хэрэгт тооцохоор зохицуулсан байна.
 - “Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, их хэмжээний эд хөрөнгийн болон бусад хор уршиг учирсан бол” гэсэн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хасжээ.
 - Зөвхөн хорих ял шийтгэхээр байсныг торгох эсхүл хорих ялын сонголттой болгож, хорих ялын хэмжээ 5-25 жилийг 2-8 жил хүртэл хугацаагаар болгож бууруулсан байна.

Энэ хууль нь 2017 оноос эхлэн 6 дах жилдээ хэрэгжиж байгаа ч 2023 оны 8 дугаар сарын байдлаар нийт 24 удаа нэмэлт, өөрчлөлт орсноос 2017.05.11-ний өдөр (хууль хэрэгжиж эхлэхээс өмнө) сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

¹⁵ “Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх, Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх, Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах гэмт хэрэг үйлдэхэд бэлтгэсэн, зохион байгуулсан”-ыг ойлгоно.

1.3.2 Өршөөлийн тухай хуулийн зохицуулалт

УИХ нь 1991 оноос хойш нийт 6 удаа /1991, 1996, 2000, 2006, 2009, 2015 он/ өршөөлийн хуулийг баталсан. Монгол Улс 1991 онд 1300-1400 орчим, 1996 онд 140 орчим, 2000 онд 1500 орчим, 2006 онд 3500 орчим, 2009 онд 3300 орчим хүнд тус тус өршөөл үзүүлсэн гэсэн тойм мэдээлэл байна¹⁶.

ХҮСНЭГТ 3. ӨРШӨӨЛД ҮЛ ХАМРУУЛАХ ЗААЛТАД БАГТСАН БАЙДАЛ

| Огноо | Үл хамруулах заалтад багтсан эсэх | Тайлбар |
|------------|--|---|
| 2006.06.23 | Төрийн эсрэг онц хүнд гэмт хэрэг /ЭХ-ийн 79-85 дугаар зүйл/ 82 дугаар зүйл хамаарна. | Онц хүнд гэмт хэрэг: 10-15 жил, 25 жил хүртэл хугацаагаар хорих буюу цаазаар авах ялтай гэмт хэргийг ойлгох ба 82-р зүйлд заасан Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах гэмт хэрэг нь 16-20 жил хорих ял оногдуулах зохицуулалттай тул хамаарахаар байна. |
| 2009.07.09 | Төрийн эсрэг онц хүнд гэмт хэрэг /ЭХ-ийн 79-85 дугаар зүйл/ 82 дугаар зүйл хамаарна. | Дээрхтэй ижил. |
| 2015.08.11 | | 2011 оны ЭХ-д орсон нэмэлт, өөрчлөлтөөр 821 орж ирсэн боловч оруулаагүй байна. |
| 2021.07.02 | Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах гэмт хэрэг/ЭХ-ийн 14.9 дүгээр зүйл/ Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйл/ зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг өршөөлд хамааруулахгүй. | |

1.3.3 Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь нэгэнт үйлдэгдсэн гэмт хэргийн араас хөөцөлдсөнөөс илүү үр дүнтэй болохыг олон улсад хүлээн зөвшөөрдөг. Манай оронд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь ихэвчлэн нийгмийн анхаарлыг татсан, хүнд гэмт хэргүүд рүү төвлөрч байгаа ба өнөөг хүртэл хэрэгжүүлсэн гэмт

¹⁶ Б.Ганболд, Өршөөлийн эрх зүй, УБ., 2015, 26, 29, 36, 41, 46 дахь тал;

хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, үйл ажиллагаануудад сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх асуудал багтаагүй байна. Түүнчлэн энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд СЕХ тодорхой чиг үүрэгтэй ба соён гэгээрүүлэх зарим үйл ажиллагаа хийдэг ч энэ нь зөвхөн сонгуулийн жилүүдэд илүү идэвхтэй байна.

Хэдийгээр сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн тоо бага байгаа ч үүнийг гэмт хэрэг үйлдэгдэхгүй байгаа мэтээр ойлгож урьдчилан сэргийлэх асуудлыг орхигдуулж болохгүй. Сонгуулийн үеийн маргааны тоо буурахгүй байгаа статистик, сонгуулиас сонгуульд нэр дэвшигчид, түүний баг, нам, дэмжигчдийн хууль бус үйлдэл илүү өргөн хүрээг хамарч, илүү чадварлаг, илүү зохион байгуулалтад орж байгааг анхаарч, энэ явдлыг таслан зогсоох, гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулах нь зүйтэй юм.

Үүний тулд, урьдчилан сэргийлэх ажлыг зөвхөн сонгогчдод чиглүүлэх бус гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй эрсдэлтэй буюу сонгуульд өрсөлдөхөөр сонирхож буй УТН, эвсэл, хөдөлгөөн, бие даагч зэрэг талуудад чиглүүлэх. Мөн сонгуулийн эрх нь хөдөлшгүй тул сонгуулийн хууль тогтоомжийн өөрчлөлтөөс үл шалтгаалан энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах бодлого, түүнийг хэрэгжилтийг сайжруулах асуудлыг хөндөх шаардлагатай байна.

ХОЁР. СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

2.1 Гэмт хэргийн нөхцөл байдал

Анх 2002 онд сонгуулийн эрхийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох зохицуулалт ЭХ-д орж, 2008 онд ЭХТА-ийн 130 болон 131-р зүйл ангиар 4 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байсан нь энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдсэн анхны тохиолдол болж байжээ. Харин 2012 онд анхны хэрэг шийдвэрлэгдэж байсан нь ЭХТА-ийн 130.2 дах хэсэгт зааснаар зүйлчлэгдэж¹⁷ байжээ.

Үндэсний статистикийн хорооноос МУ дах гэмт хэргийн нөхцөл байдлын мэдээг он, оноор бэлтгэн Статистикийн мэдээллийн нэгдсэн 1212.mn цахим сангаар танилцуулж байна. Энэ сан дах 2013-2021 оны Гэмт хэргийн танилцуулгад, Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн статистик, ерөнхий буюу тухайн онд бүртгэгдсэн нэгдсэн дүнгээр байна. Үүнээс сонгуулийн жилүүдийг дэлгэрүүлж үзэхэд, өөрчлөлтгүй байх бөгөөд ЭХТА-ийн 14-р бүлэг, Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн статистик нь “бусад” гэсэн ангилалд багтаж байна. Энэ төрлийн гэмт хэрэг нь шинэ ЭХ хэрэгжиж эхэлснээс хойш цагдаагийн байгууллагад бүртгэгдэх нь эрс буурсан буюу 2-6 болсон байна.

¹⁷ <https://shuukh.mn/>

ГРАФИК 1. ХҮНИЙ ХУВИЙН, УЛС ТӨРИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ТОО:¹⁸



Шүүхийн шийдвэрийн цахим сангаас энэ төрлийн гэмт хэргийн шийдвэрийг шүүж үзэхэд 2002-2022 оны 6 дугаар сарын байдлаар нийт 8, сонгуулийн үеэр сонгуулийн эрхэд халдсан ч өөр зүйл ангиар (2002 он ЭХТА 111, шинэ ЭХТА 14.8) зүйлчлэгдсэн 2, нийт 10 гэмт хэрэг байна.

ХҮСНЭГТ 4. ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭЛЭЛ¹⁹

| Он | 2002 оны ЭХТА-ийн холбогдох зүйл, хэсэг | | | | | |
|---------|---|-------|--------|-------|--------|------|
| | 111.1 | 111.2 | 130.1 | 130.2 | 131.1 | Нийт |
| 2012 он | 1 | 0 | 0 | 2 | 0 | 3 |
| 2013 он | 0 | 1 | 0 | 2 | 1 | 4 |
| 2016 он | 0 | 0 | 0 | 1 | 0 | 1 |
| Он | 2015 оны ЭХТА-ийн холбогдох зүйл, хэсэг | | | | | |
| | 14.5 | 14.6 | 14.7.1 | 14.8 | 14.9.1 | Нийт |
| 2019 он | 0 | 0 | 0 | 0 | 1 | 1 |
| 2021 он | 0 | 0 | 1 | 0 | 0 | 1 |

¹⁸ <http://1212.mn/>

¹⁹ <https://shuukh.mn/cases/2/1>

Судалгааны ажлын хүрээнд, гэмт хэргийн талаар статистик, тоо баримт бэлтгэн танилцуулж буй байгууллагуудад хандсан албан хүсэлтийн дагуу ирүүлсэн статистикийг доор харууллаа.

- **Цагдаагийн Ерөнхий Газар:** ЦЕГ-аас холбогдох статистикийг цагдаагийн байгууллагад “сонгуулийн эрх зөрчсөн” агуулгаар ирүүлсэн гомдол, мэдээллийн тоо болон ЭХТА-ийн 14 дүгээр бүлэгт хамаарах зүйл ангиар хэрэг үүсгэж шалгасан хэргийн мэдээлэл болгон ангилж ирүүлсэн байна. Статистик, мэдээллийн хугацааны хувьд 2016-2022 оны хооронд байгаа бол энэ хугацаанд ирүүлсэн гомдол мэдээллийн тоо 4-1707, үүнээс хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн тоо 3-899 хүртэл байна. Харин дээрх гомдол, мэдээллээс хэрэг бүртгэлийн хэрэг үүсгэж шалгасан тоо 15 байгаагаас 10-т нь хэрэг үүсгэхээс татгалзаж, 5 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж шалгасан байна.

ХҮСНЭГТ 5. ЦЕГ: 2016-2022 ОНД МОНГОЛ УЛСЫН ЭХТА-ИЙН 14 ДҮГЭЭР БҮЛГИЙН ХОЛБОГДОХ ЗҮЙЛ АНГИАР ХЭРЭГ ҮҮСГЭЖ ШАЛГАСАН ХЭРГИЙН ТОО, ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛСЭН ХЭРГИЙН ТОО

| № | Зүйл хэсэг | Он | Гомдол хүлээн авч, шалгасан | Хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн |
|----|--|---------|-----------------------------|--|
| 1. | 14.5.1 Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хий | 2018 он | 1 | |
| | | 2019 он | 5 | 4 |
| | | 2020 он | 1 | 1 |
| | | 2021 он | 1 | |
| 2. | 14.7.1 Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах | 2018 он | 1 | 1 |
| | | 2019 он | 2 | 2 |
| 3. | 14.8.1 Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах | 2020 он | 3 | 2 |
| | | 2021 он | 1 | |

- **Шүүхийн Ерөнхий Зөвлөл:** ШЕЗ-өөс ирүүлсэн шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргийн статистик нь шинэ ЭХ хэрэгжиж эхэлснээс хойших буюу 2018-2021 оныг хамаарч байна. Энэ хугацаанд шүүхээр шийдвэрлэсэн сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн тоо 1 буюу 2019 онд 14.9.1 дэх хэсэгт заасан сонгууль хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулсан зүйл ангиар шийдвэрлэгджээ.

ХҮСНЭГТ 6. “ХҮНИЙ ХУВИЙН, УЛС ТӨРИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ”-ИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН МЭДЭЭЛЭЛ /2018-2021 ОН/

| Огноо | Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл, заалт | | | | | | | | | |
|-------|--|------------|------------|----------|----------|----------|------------|----------|------------|------------|
| | 14.1 дүн | 14.2.1 дүн | 14.3.1 дүн | 14.4 дүн | 14.5 дүн | 14.6 дүн | 14.7.1 дүн | 14.8 дүн | 14.9.1 дүн | 14-р бүлэг |
| 2018 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2019 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 1 |
| 2020 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 2021 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 |

ЦЕГ, ШЕЗ-ийн дээрх статистикийг цахим сан дах шүүхийн шийдвэрүүдтэй харьцуулахад, мэдээлэл дараах байдлаар зөрж байна.

- Шинэ ЭХ-ийн холбогдох заалт 14.5-14.9 дэх хэсгээр зүйлчилж шийдвэрлэсэн хэрэг цахим санд 2 (2019 он - 14.9.1; 2021 он - 14.7.1) байгаа бол ЦЕГ-ын статистикт, Шүүхэд шилжүүлсэн хэргийн тоо 5, ШЕЗ-ийн статистикт, шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо 1 байна.
- Дээрх 2 хэргийн зүйлчлэл, шийдвэрлэсэн оноор ЦЕГ-ын мэдээлэлтэй харьцуулахад аль аль нь зөрүүтэй байгаа бол, ШЕЗ-ийн статистиктай харьцуулахад, 2021 онд шийдвэрлэсэн хэргийн мэдээлэл байхгүй байна.
- ЦЕГ-аас ирүүлсэн статистикаас шүүхэд шилжүүлсэн хэргийн тоо 5 байхаар харагдаж байгаа ч, цахим сан болон ШЕЗ-ийн статистикт хэргийн мэдээлэл байхгүй байна.

ЦЕГ-аас ирүүлсэн статистикаас “Сонгуулийн эрх зөрчигдсөн” агуулгаар ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо сонгуулийн жилүүдэд жирийн үеийнхтэй харьцуулахад хэд дахин өссөн байна. Тухайлбал, УИХ-ын сонгууль болсон онуудад 2016 онд - 683, 2020 онд - 1707, Ерөнхийлөгчийн сонгууль болсон 2017 онд - 168, 2021 онд - 163 өргөдөл, гомдлын хүлээн авсан бол энэ тоо сонгуулийн бус жилүүдэд, жилд дунджаар 17 орчим байна. Хүлээн авсан өргөдөл, гомдолд хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн тоо савлагаатай, харилцан адилгүй байгаа бөгөөд тухайлбал, 2017 онд 183-аас 176-г нь буюу 96.2 хувь орчимд, 2016 онд 630-аас 53-т нь буюу 8.4 хувьд хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэжээ.

ХҮСНЭГТ 7. 2016-2022 ОНД СОНГУУЛИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ ЗӨРЧСӨН ГЭСЭН АГУУЛГАТАЙ ГОМДОЛ ХҮЛЭЭН АВЧ ШАЛГАСАН ТОО

| № | Он | Гомдол хүлээн авч, шалгасан тоо | Хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн тоо |
|----|---------|---------------------------------|--|
| 1. | 2016 он | 630 | 53 |
| 2. | 2017 он | 183 | 176 |
| 3. | 2018 он | 15 | 5 |
| 4. | 2019 он | 32 | 17 |
| 5. | 2020 он | 1707 | 899 |
| 6. | 2021 он | 163 | 138 |
| 7. | 2022 он | 4 | 3 |

Цагдаагийн байгууллага нь гомдол мэдээлэлд зөрчлийн болон эрүүгийн хэрэг үүсгэн шалган шийдвэрлэх боломжтой бөгөөд 2016-2022 онд нийт 15 эрүүгийн хэрэгт ажилласан бол 2020, 2021 онуудад нийт 196 зөрчлийн хэргийг шийдвэрлэж хариуцлага оногдуулсан байна.

ХҮСНЭГТ 8. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙГ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭСЭН СТАТИСТИК (ХУВИЙН ЭХ СУРВАЛЖААС)

| | Зөрчлийн хуулийн 17.1 | | | | | |
|--------------------|-----------------------|------|------|----------|----------|-------------|
| | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022.07 сар |
| Зөрчил | | | | 181 | 15 | |
| Торгууль /мян.төг/ | | | | 252200.0 | 170000.0 | |

Улсын хэмжээнд сүүлийн 20 жилийн хугацаанд (2002-2022 он) сонгуулийн эрхийн эсрэг нийт 10 гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэсэн байдаг ба үүнээс 8 хэрэгт ял оногдуулж, 2 хэргийг цагаатгаж шийдвэрлэжээ.²⁰ Одоогоор энэ төрлийн гэмт хэргийг Давж заалдах болон Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн мэдээлэл байхгүй байна.


²⁰ Шүүхийн шийдвэрийн цахим сан дахь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрүүд <https://shuukh.mn/>

Шийдвэрлэсэн хугацааг авч үзвэл, 2012 онд 3, 2013 онд 4, 2016 онд 1, 2019 онд 1, 2021 онд 1 хэрэг байна. Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацааг, сонгуулийн хэлбэртэй хамтатган авч үзвэл, 2012 оны УИХ-ын сонгуулийн үеэр 4, 2012 оны орон нутгийн ИТХ-ын сонгуулийн үеэр 3, 2015, 2018 онуудад тосгоны захирагч томилох сонгуулийн үеэр 2, 2016 оны УИХ-ын сонгуулийн үеэр үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 1 байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн хувьд, орон нутагт 80 хувь, нийслэлд 20 хувь нь буюу 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Гэмт хэргийн 50 хувь нь иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд саад учруулах-сонгогчийн саналыг татахаар мөнгө, эд зүйл тараасан, 20 хувь нь иргэний сонгогдох эрхэд саад учруулж гүтгэсэн, 10 хувь нь сонгуулийн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, 10 хувь нь сонгуулийн санал хураалтын дүнг буруу гаргасан, 10 хувь нь сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах гэмт хэргүүдээр зүйлчлэгдсэн байна.

ГРАФИК 2. ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛ




ХҮСНЭГТ 9. ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛ

| Хуулийн зохицуулалт | Хэргийн зүйлчлэл | Хэргийн тоо |
|---|------------------|-------------|
| 2002 оны ЭХТА-ийн зүйлчлэл: | | |
| 111 дүгээр зүйл. Гүтгэх | 111.1 | 1 |
| | 111.2 | 1 |
| 130 дугаар зүйл. Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх | 130.2 | 5 |
| 131 дүгээр зүйл. Сонгуулийн болон бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах | 131.1 | 1 |
| 2015 оны ЭХТА-ийн зүйлчлэл: | | |
| 14.7 дугаар зүйл. Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах | 14.7.1 | 1 |
| 14.9 дүгээр зүйл. Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах | 14.9.1 | 1 |

Нийт хэргээс 6 нь хохирогчийн гомдлоор хэрэг үүсгэсэн ба энэ 6 хэрэгт нийт 8 иргэн хохирсон байна. Хохирогчдын хувьд, бүгд сонгуульд нэр дэвшиж оролцсон, сонгуулийн үеэр өөрийн сонгогдох эрх зөрчигдсөн гэж үзэж, уг эрхээ сэргээлгэхээр цагдаагийн байгууллагад ханджээ. Хохирогчдыг төлөөллийн хувьд авч үзвэл, АН-ын 6, бие даан нэр дэвшигч 2 байна.


ГРАФИК 3. ХОХИРОГЧДЫН УЛС ТӨРИЙН НАМЫН ХАРЬАЛАЛ



Гэмт хэргийн хохирогчдоос сонгуульд бие даан нэр дэвшиж оролцсон 2 хохирогч нь өөрт учирсан бодит хохирлоо мөнгөн дүнгээр тооцож, нийт 2'712'680 төгрөгийг нэхэмжилсэн байна. Хохирол тооцохдоо, сонгуульд бэлтгэн оролцсон зардал, сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалын төлбөр болон сурталчилгааны үеэрх тээврийн хөлс зэргийг багтаажээ.

Шүүхээс гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 2'712'680 төгрөгийн хохирлоос, зөвхөн 1 хэрэгт, шүүгдэгчээс хэрэг мөрдөн байцаалтын шатанд хохирогчид төлсөн 392'800 төгрөгийг хохирол төлсөнд тооцож, нэхэмжлэлийн бусад шаардлагыг нотлох баримтын шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ.

ГРАФИК 4. СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧДЫН УЛС ТӨРИЙН НАМЫН ХАРЬАЛАЛ




Шүүхээр шийдвэрлэгдсэн 10 хэрэгт 17 этгээд холбогдон шалгагдсан ба 4 этгээд нь шүүхийн шатанд цагаатгагдсан байна. Эдгээр холбогдогчдын УТН-ын харьяаллыг авч үзвэл, зөвхөн 1-ээс бусад нь МАН-ын гишүүд, дэмжигчид байна.

10 гэмт хэрэгт 17 холбогдогч байгаагаас 1 гэмт хэргийн шүүгдэгчийн биеийн байцаалтын мэдээлэл тодорхойгүй, бусад холбогдогчийн мэдээлэл шүүхийн шийдвэрт бичигдсэн байна. Шүүхийн шийдвэр дэх мэдээлэлд үндэслэн холбогдогчдын нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлтийн байдал зэрэг мэдээллийг дэлгэрүүлэн графикаар үзүүлэв.

ГРАФИК 5. СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧИЙН НАС, ХҮЙСИЙН МЭДЭЭЛЭЛ



ГРАФИК 6. СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧДЫН БОЛОВСРОЛ, АЖИЛ ЭРХЛЭЛТ



2.1.1 Гэмт хэргийн үйлдлийн арга

Гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах, шийдвэрлэх, урьдчилан сэргийлэхэд тухайн гэмт хэрэг үйлдэгдэн гарч буй бүхий л арга болон оролцогч нэг бүрийн үйлдэл, оролцооны талаар нарийвчлан судалж, тодорхойлох нь практикийн чухал ач холбогдолтой бөгөөд хэргийг зөв зүйлчилж, шалган шийдвэрлэхэд дөхөм болдог. Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг нь дараах арга, хэлбэрүүдээр голчлон илэрч байна. Үүнд:

1. Нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 50 хувийг эзэлж байгаа сонгогчийг эд хөрөнгө, мөнгөөр татаж санал худалдаж авч үйлдэх гэмт хэрэг нь:
 - Иргэдтэй түрээсийн гэрээ байгуулах нэрээр халхавчлан нийт 17 иргэнд тус бүр 100'000-150'000 төгрөг өгөх байдлаар нийт 2'150'000 төгрөг тараасан,
 - Нэр дэвшигчдээс сонгогчидтой хийсэн уулзалтад ирсэн иргэдэд 2'000-15'000 төгрөгийн бензинийг нийт 14 иргэнд үнэгүй өгсөн,
 - Иргэдийг машинаар зөөн, ... нэр дэвшигчид саналаа өгөөрэй гэх байдлаар 10'000-20'000 төгрөг тараасан,
 - Сонгуулийн үеэр айлын гэрт очиж ... нэр дэвшигчид санал өгөөрэй гэх байдлаар 100'000-300'000 төгрөгийг тараах байдлаар үйлдэгдсэн байна.
2. Сонгуулийн үеэр худал мэдээлэл тараах гэмт хэрэг хуульчлагдаагүй байх үед 2002 оны ЭХ-ийн 111 дүгээр зүйлд зааснаар, сонгуульд нэр дэвшигчийн нэр хүндийг унагаах зорилгоор худал мэдээлэл тарааж гүтгэсэн гэмт хэргийн үйлдлийн арга нь:
 - Өдөр тутмын сонинд нэр дэвшигчийн талаар худал мэдээлэл нийтэлсэн,
 - Хэвлэлийн бага хурал зарлаж, нэр дэвшигчийн талаар худал мэдээлэл тараасан.
3. Санал хураалтын дүнг буруу гаргасан буюу сонгуулийн нэгдсэн хорооны дарга сонгуулийн үр дүнг танилцуулахдаа хүчингүй 41 саналын хуудсыг нийт саналаас хасаж, хорооны гишүүд, нарийн бичгийн дарга нарт буруу мэдээлсэн.
4. Сонгуулийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдсэн буюу бие даан нэр дэвшигчийг дэмжигчийн өмнөөс өргөдөл гаргаж, тус өргөдөлдөө тухайн иргэний гарын үсэг дуурайлгаж зурж, нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтаас хасуулсан.
5. Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулсан буюу төрийн албан тушаалыг мөнгөөр үнэлж, бохир технологи ашиглах, тусгай ажиллагааны баг байгуулж, судалгаа хийлгэн ажиллуулсан, түүнийгээ бусдад танилцуулах, хэрэгжих боломжийг эрэлхийлэх үйлдэл хийсэн.

2.1.2 Гэмт хэрэгт хамтран оролцох²¹ хэлбэр

ЭХ-ийн ерөнхий ангид, гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэрийг зааж, энэ нь эрүүгийн хэрэгт ял оногдуулахад хүндрүүлэх нөхцөл болдог. Харин ЭХТА-д гэмт хэргийг бүлэглэж үйлдсэнийг хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон заасан байдаг. Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн тухайд, хамтран оролцсон буюу бүлэглэн үйлдсэнийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй байхаар хуульчлаагүй бөгөөд ЭХТА-ийн зөвхөн 14.9.1 дэх хэсэгт, “Сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх зорилгоор энэ хуулийн 14.5, 14.6, 14.7 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдэхэд бэлтгэсэн, зохион байгуулсан бол...ял шийтгэнэ” гэжээ.

Шүүхээр шийдвэрлэсэн сонгуулийн эрхийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргүүдийн нэг онцлог нь санаа зорилго тодорхой, урьдаас төлөвлөж, зохион байгуулалттайгаар үйлдсэн байдал ажиглагдлаа. Тухайлбал, шүүхээр шийдвэрлэгдсэн 10 хэргийн 6-д нь 2-3 этгээд хамтран гүйцэтгэсэн болох нь хэргийн мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоож шүүхэд шилжүүлсэн байна. Харин эдгээрээс шүүх, нэр дэвшигч нь хэрэгт холбогдсон 2 хэргийн 1-ийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, нөгөө хэрэгт нь нэр дэвшигчид холбогдох үйлдэл нь нотлогдоогүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Бусад хэргийн тухайд, 2 хэрэгт алинд нь ч хэрэгт гэмт хэргийг бүлэглэн үйлдсэнийг ял оногдуулах хүндрүүлэх нөхцөлд харгалзсан бол үлдсэн 2 хэрэгт хайхрахгүй орхисон байна. Цагаатгагдсан 2 нэр дэвшигчийн хувьд хэн хэн нь сонгуульд ялалт байгуулсан байсан нь хохирогчдын мэдүүлгээс тодорхой байна.

2.2 Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүн ба зүйлчлэлийн асуудал

Аливаа үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцоход түүний бүх шинжийг хуульд тодорхой заасан байх ёстой бөгөөд энэ нь эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх хууль ёсны зарчмын гол үндэслэл болно. Иймд гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, гэм буруутай этгээдэд тохирсон ял, шийтгэл оногдуулахад гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал чухал ач холбогдолтой. Гэмт хэргийн зүйлчлэлээр гэмт этгээдийн үйлдсэн нийгэмд аюултай хэрэг, эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой хэм хэмжээнд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бүхий л шинжтэй нарийн нийцэж байгааг тогтоож, мөрдөн шалгах ажиллагаагаар бэхжүүлдэг.²²

²¹ ЭХ-ийн 3.1.1 дэх хэсэг: Хоёр, түүнээс олон хүн гэмт хэрэг үйлдэхэд санаатай нэгдсэнийг гэмт хэрэгт хамтран оролцох гэнэ.

²² С.Нарангэрэл, Гэмт хэргийн зүйлчлэлийн шинжлэх ухааны үндэс, УБ., 1988, 8 дахь тал;

2.2.1 Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүн

Гэмт хэргийн бүрэлдэхүүн нь гэмт хэргийн объект, объектив тал, субъект субъектив тал гэсэн 4-н шинжид хуваагддаг. Эдгээр нь нийлж, гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоож бусад гэмт хэргээс ялгагдах гол онцлог болдог.

Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийг ЭХТА-д заасан иргэний улс төрийн эрх, эрх чөлөөнд халдаж хохирол учруулсан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэж тодорхойлж болно. Өөрөөр хэлбэл, сонгуулийн эрх, эрх чөлөөнд халдсан үйлдэл бүрийг гэмт хэрэгт тооцохгүй бөгөөд хэрэв иргэний сонгуулийн эрх, эрх чөлөөнд халдсан ч доорх шинжийн аль нэг нь байхгүй бол түүнийг гэмт хэрэг гэж үзэх боломжгүй. Үүнд:

1. ЭХ-ийн тусгай ангид заасан байх,
2. Нийгэмд аюултай байх,
3. Гэм буруутай байх,
4. Хохирол, хор уршиг учирсан байх юм.

Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг ЭХТА-д тогтоосон байдлыг авч үзвэл:

1. Объект – Иргэний улс төрийн эрх, эрх чөлөө - сонгуулийн эрх;
2. Объектив тал – ЭХТА-д сонгуулийн эрх, эрх чөлөөнд халдсан дараах үйлдэл, эс үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор заасан. Үүнд:
 - Иргэний сонгох, сонгогдох, ард нийтийн санал асуулгад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд; сонгуулийн хорооноос хуулийн дагуу явуулж байгаа үйл ажиллагаанд зориуд саад учруулсан,
 - МУ-ын Ерөнхийлөгчийн, УИХ-ын, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, ард нийтийн санал асуулгад нэгээс илүү удаа санал өгсөн; нэгээс илүү удаа санал өгөхийг зохион байгуулсан,
 - Сонгууль, ард нийтийн санал асуулгыг зохион байгуулах хорооны дарга, гишүүн, эсхүл бусад албан тушаалтан улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулсан; сонгогчийн санал өгөх, хураах, тоолох ажилд зориуд саад хийсэн; бусдыг төлөөлж санал өгөх, саналын хайрцгийн лац, битүүмжлэлийг зориуд гэмтээх, гарын үсэг хуурамчаар үйлдэх, саналын хуудас солих, хүчингүй саналын хуудсаар санал авахыг зохион байгуулсан; хатгасан; дэмжсэн; санал хураалтын дүнг өөрчилсөн,

- Сонгуульд оролцогч УТН, эвсэл, нэр дэвшигчдийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан,
 - Сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх зорилгоор энэ хуулийн 14.5, 14.6, 14.7 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдэхэд бэлтгэсэн, зохион байгуулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор заажээ.
3. Субъект – гэмт хэрэг үйлдсэн, эрүүгийн хариуцлага хүлээх чадвартай хүн. Тусгайлан заасан субъектын тухайд, сонгууль зохион байгуулах хорооны дарга, бусад албан тушаалтан, төрийн албан хаагч, сонгуулийн хорооны албан тушаалтан, ажилтан;
- Субъектив тал – гэмт хэргийн дотоод агуулга буюу санаа, зорилго нь, сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх, иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд саад учруулах буюу сонгогч саналаа чөлөөтэй өгөх боломжийг хязгаарлах, сонгогчид нөлөөлөх; Сонгуулийн явцыг будилаантуулах; Нэр дэвшигчийн нэр хүндийг унагаах зэрэг байна.

Хэрэв сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн үндсэн шинж нь бүрэн хангагдсан гэж үзвэл хүндрүүлэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзэж, хуулийн холбогдох зүйл заалтаар зүйлчлэн, гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

ЭХТА-д заасан гэмт хэргийг материаллаг болон хэлбэрийн гэж ангилдаг. Материаллаг бүрэлдэхүүнтэй гэдэг нь тухайн гэмт хэргийн төгсгөлд бодитой хор уршиг буй болгохоор тогтоосныг ойлгодог бол хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэдэг нь ЭХ-д заасан үйлдэл бүрэн хийгдсэнээр төгссөнд тооцож, гэмт хэрэгт бодитой хор уршиг шаардахгүй. Энэ шинжийн дагуу сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргүүд нь бүгд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байна.

2.2.2 Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал

Эрүүгийн хэргийн зүйлчлэлийн асуудал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үе шат бүрд хийгддэг. Гэмт хэргийг зүйлчлэх явцад гэмт хэргийн бодит байдал, үйлдлийн үр дагавар тогтоогддог учир гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх хууль зүйн үндсийг тодорхойлдог. Үүгээр тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж хангалттай эсэх нь илэрхийлэгдэнэ.²³ Иймд энэ төрлийн гэмт хэргийн зүйл заалтуудад заасан зарим нэр томъёо, үйлдлийг хууль зүйн талаас нь дэлгэрүүлж тайлбарлах²⁴ нь хэргийг зөв зүйлчлэхэд ач холбогдолтой байж гэмт хэргийн талаар шийдвэр гаргалтын суурь болдог.

²³ Б.Ганболд, Гэмт хэрэг зүйлчлэлийн онол, УБ., 2001, 67 дахь тал;

²⁴ Хавсралт 1-д зарим тайлбарыг оруулав.

Төсөөтэй бусад гэмт хэргээс ялган зүйлчлэх нь: Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийг адил төстэй бусад гэмт хэргээс ялган зааглаж авч үзэх нь тухайн гэмт хэргийн объектив, субъектив шинж ба хүндрүүлэх бүрэлдэхүүний элемент бүрийг задлан шинжилж энэ гэмт хэргийн зүйлчлэлийн үндэслэлийг боловсронгуй болгох шүүхийн практикт тохиолддог эрх зүйн хийдэл, зөрчлийг арилгахад ач холбогдолтой.

Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг нь үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хор хохирол учруулдаг тул, үүгээрээ МУ-ын дотоод аюулгүй байдалд халдсан гэмт хэргийн шинжийг агуулсан байдаг. Тухайлбал, 2019 онд Баянгол дүүргийн ЭХАШШ-ээр шийдвэрлэсэн “60 тэрбумын хэрэг” буюу “Шүүгдэгч С, Г нар нь бүлэглэн 2016 оны УИХ-ын ээлжит сонгуульд бэлтгэн, 2014 оноос эхлэн төрийн албан тушаалыг мөнгөөр үнэлж намынхаа сонгуулийн бүтцэд оруулж, сонгуулийн санал авах, тоолох зориулалт бүхий хар машины программ хангамж, сул талыг судлах талаар болох бохир технологи ашиглахаар хуйвалдан, тусгай ажиллагааны бүлэг байгуулж, судалгаа хийлгэн ажиллуулсан, түүнийгээ бусдад танилцуулах, хэрэгжих боломжийг эрэлхийлсэн” гэмт хэргийг 2002 оны ЭХТА-ийн 82.1. Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах гэж зүйлчилж шүүхэд шилжүүлснийг, шүүхээр шийдвэрлэхдээ шинэ ЭХТА-ийн 14.9. Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах болгож, зүйлчлэлийг өөрчилжээ.

Гэмт хэрэгт цугларсан нотлох баримтаас үзэхэд, гэмт этгээдүүд, сонгуулийн үр дүнг ямар нэг байдлаар өөрийн намын талд гаргах санаа агуулж энэ гэмт хэргийг үйлдсэн байдаг. Гэвч нөгөө талаас, сонгуулийн үр дүнгээр төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх албан тушаалд сонгогддог тул сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх нь төрийн эрх мэдлийг хууль бусаар авах гэсэн санаа зорилго бас агуулж байгаа юм. Энэ тохиолдолд, сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийг, төрийн эрх мэдлийг хууль бусаар авах саатуулах гэмт хэргээс ялган зүйлчлэхдээ санаа зорилгыг нарийвчлан тодруулах шаардлага ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, ЭХТА-ийн 14.9-д заасан Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах гэмт хэрэг нь, “Хууль ёсны дагуу явагдаж байгаа сонгууль, түүний үр дүнд нөлөөлж, будилаантуулах” зорилгоор үйлдэгдэх бол, Шинэ ЭХТА-ийн 19.2.²⁵-т заасан Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, саатуулах

²⁵ 19.2.1 Төрийн эрх барих дээд байгууллагын эрх мэдлийг хууль бусаар авах, хадгалах зорилгоор үгсэн тохирч хүчирхийллийн аргаар авахад бэлтгэсэн, зохион байгуулсан, оролцсон, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн; төрийн эрх барих дээд байгууллагын эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хүч хэрэглэн саад учруулсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

гэмт хэрэг нь төрийн эрх мэдлийг “сонгуулийн бус” арга буюу хүчирхийллийн аргаар авахаар бэлтгэсэн, зохион байгуулсан үйлдлийг ойлгож болохоор байгаа юм.

Зүйлчлэлийн талаар тус гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн БГД-ийн ЭХАШШ-ийн тайлбарыг үзвэл:

...2002 оны ЭХТА-ийн 82.1-д заасан “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах” гэмт хэрэг нь хууль тогтоомжийн дагуу төрийн эрх барьж байгаа хүчнээс засгийн эрх мэдлийг нөгөө улс төрийн хүчин буюу эвсэл, тодорхой этгээд хүчирхийллийн болон хуурамч арга хэрэглэн булаан авахыг ойлгоно.

Шүүгдэгч нарт холбогдох хэргийн үйл баримтаас үзвэл тэдгээрийн үйлдэл нь “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах” гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, харин “Сонгуулийг будлиантуулж төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах” буюу 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 82.1 дүгээр зүйлийн 82.1.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй байна гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ. Өөрөөр хэлбэл төрийн эрх мэдлийг хуульд зааснаар байгуулах, өөрчлөх, огцруулах, тараах үндэслэл, журмаас гадуур хууль бус арга хэрэглэж авах бус 2016 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нөлөөлж зохион байгуулалттайгаар будилаантуулах, ингэж будилаантуулахын тулд урдаас үгсэн тохирч бэлтгэсэн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулж байна. ... Шүүгдэгч нар нь сонгуулийн санал хураалтын дүнг өөрчлөх ... гэмт хэргийг үйлдэхээр завдсан гэж үзэх хууль зүйн үндэслэлтэй байна.

... “шүүх нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн зүйлчлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.9 дүгээр зүйлийн 1-д “Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ” гэж заасан байх тул оногдуулах ялыг хөнгөрүүлсэн хуулийг буцаан хэрэглэж хуулийн дээрх зохицуулалтыг журамлан нэр бүхий шүүгдэгч нарыг 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох нь зүйтэй гэж шүүх дүгнэлээ... гэжээ.

Дээрх тайлбар нь 2002 оны ЭХТА-ийн 82.1 болон 82.11-ийг үндэслэн тайлбарласан ба 82.1-д зөвхөн “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авахаар хуйвалдаан зохион байгуулсан” тухай байсан бол шинэ ЭХ-ийн зохицуулалтаар “төрийн эрх барих

дээд байгууллагын эрх мэдлийг ... хүчирхийллийн аргаар авахад бэлтгэсэн, зохион байгуулсан ..." гэж өөрчилсөн. Шинэ ЭХ-иар төрийн эрх мэдлийг сонгуулийн аргаар авахаар бэлтгэсэн, зохион байгуулсан тухай зохицуулалт гээгдсэнээс гадна, сонгуулийн бус болон хүчирхийллийн бус аргаар төрийн эрх мэдлийг хууль бусаар авах үйлдлийг гэмт хэрэгт тооцох асуудал өмнөх хуулиас орхигдсон байна. Ингэснээр, сонгууль бол хүчирхийллийн арга биш тул энэ 2 гэмт хэргийг үйлдсэн гэж давхар зүйлчлэх боломжгүй болж байгаагаас гадна ээлжит сонгуулийн хугацаанаас өмнө төрийн эрх мэдлийг хууль бусаар, хуурамч арга хэрэглэн авахаар хуйвалдаан зохион байгуулсан буюу хүчирхийллийн бус аргаар үйлдэхээр бэлтгэсэн, зохион байгуулсан үйлдлийг шийдвэрлэх хуулийн зохицуулалтгүй байхгүй байна.

Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийг өөр бусад төсөөтэй хэргээс ялган зүйлчлэхэд дараах нөхцөл байдлуудыг анхаарах нь зүйтэй. Үүнд:

1. Иргэний сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулах зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлсэн бол 14.5-аар зүйлчлэх бөгөөд ЭХТА-ийн 13.5-д заасан Заналхийлэх гэмт хэрэгтэй объектив талын шинж болох үйлдлээрээ ижил боловч объектоороо ялгагдана.
2. Сонгогчийг эд хөрөнгө, мөнгөөр татаж, нэр дэвшигч, санал өгөх үйл явцын талаар зориуд худал мэдээлэл өгч, хууран мэхэлж, төөрөгдөлд оруулах замаар санал өгүүлсэн нь ЭХТА-ийн 17.3-д заасан Залилах гэмт хэргийн шинжтэй төсөөтэй боловч, "бусдын өмчлөх эрх", "сонгуулийн эрх" байх объектоороо ялгагдана.
3. Явуулж байгаа үйл ажиллагаатай нь холбогдуулан сонгуулийн хорооны албан тушаалтан, түүний ойр дотнын хүнийг заналхийлж, сүрдүүлсэн бол ЭХТА-ийн 23.7-д заасан нийтийн албан тушаалтныг заналхийлэх гэмт хэргээр зүйлчилнэ.
4. Сонгуульд ажиллаж байгаа холбогдох албан тушаалтан нэр дэвшигч, эсвэл нам, эвслийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах, сонгогчдын итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх, боломжит сонгогчдын анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр сурталчилгаа явуулсан бол ЭХТА-ийн 14.7-р зүйлчилнэ.
5. Нэр дэвшигчийг хувь хүнийх нь нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор гүтгэсэн бол ЭХТА-ийн 14.8-д зааснаар зүйлчлэх бол, хэрэв энэ үйлдлийг сонгуулийн бус цагаар хийсэн бол ЭХТА-ийн 13.14-д заасан худал мэдээлэл тараах гэснээр зүйлчилнэ.

Одоогоор шүүхээр хянан шийдвэрлэгдсэн сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт давхар зүйлчилсэн тохиолдол байхгүй байгаа ч дараах тохиолдолд давхар зүйлчилнэ. Үүнд:

1. Иргэний сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад хийх зорилгоор эрүүл мэндэд нь хохирол учруулсан ЭХ-ийн 14.5 дугаар зүйл, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тохирох зүйлээр,
2. Сонгуулийн хорооноос хуулийн дагуу явуулж байгаа үйл ажиллагаанд зориуд саад учруулж, эсэргүүцэх явцдаа хэв журмыг зөрчиж, эд хөрөнгө устгаж гэмтээж, олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулсан бол ЭХ-ийн 14.5 болон 20.16 дугаар зүйлээр,
3. Сонгуулийн хорооны албан тушаалтныг явуулж байгаа үйл ажиллагаатай нь холбогдуулан, өөрийг нь болон ойр дотнын хүнийг нь заналхийлж, сүрдүүлснээс сонгуулийн хорооны хэвийн үйл ажиллагаа алдагдаж иргэн сонгуулийн эрхээ хэрэгжүүлж чадаагүй бол ЭХ-ийн 14.5 болон 23.7 дугаар зүйлээр,
4. Сонгогчдоор нэгээс илүү санал өгүүлэх зорилгоор эд, мөнгө тараасан бол ЭХ-ийн 14.5, 14.6 дугаар зүйлээр,
5. Нэр дэвшигчийн хувийн нууцыг задруулах замаар илт худал гүтгэлэг тараасан бол ЭХ-ийн 14.8, 13.11 Хувь хүний нууцыг задруулах гэмт хэргээр,
6. Энэ төрлийн гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн нь хүндрүүлэх бүрэлдэхүүн байхгүй ч ЭХТА-ийн 14.9-р зүйлийн “зохион байгуулсан” үйлдлийг, ЭХТА-ийн 20.3. Зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулах, түүнд элсэх гэснээр давхар зүйлчлэх боломжтой нөхцөл харагдаж байна.

Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн хамаарал: Хууль зөрчсөн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас ЭХ-д заасан хохирол учруулаагүй бол гэмт хэргийн үндсэн шинж үгүйсгэгдэн “эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол” гэх үндэслэлээр зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулдаг. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэсэн нь гэмт хэрэг, зөрчлийг объектив, субъектив шинжээр, эсхүл тодорхой хохирол, хор уршиг учруулсан мөнгөн дүнгээр ялган зааглахыг хэлдэг.

Зөрчлийн тухай хуульд, “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг²⁶ зөрчсөн,

²⁶ Захиргааны хэм хэмжээ гэж “Хуулиар эрх олгосон хүрээнд Төрийн эрх бүхий байгууллага Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу боловсруулж, баталсан нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам” юм.

энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ.” хэмээн тодорхойлсон. Мөн хуулийн 17 дугаар бүлэгт, Улс төрийн эрх, эрх чөлөөний зөрчил, 17.1 дэх хэсэгт Сонгуулийн хуулийг зөрчих гэсэн зүйлээр 36 зөрчлийг зааж, зөрчилд зөвхөн торгох шийтгэл оногдуулах зохицуулалттай байна. Эдгээрээс зарим зөрчлийг Эрүүгийн хэргийн шүүх²⁷, болон Тагнуулын байгууллага харьяалан шийдвэрлэхээр заасан. Энэ тохиолдолд тухайн зөрчлүүдийг ЭХТА-д ангид заасан төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх асуудал хөндөгдөх юм.

ХҮСНЭГТ 10. СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТӨСӨӨТЭЙ ЗӨРЧЛҮҮД

| ЭХТА-ийн холбогдох зүйл анги | Зөрчлийн тухай хуулийн зохицуулалт |
|--|--|
| 14.5.2.3 ...сонгогчийг эд хөрөнгө мөнгөөр татаж санал худалдан авч үйлдсэн бол ... | 17.16. ... ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, ... сонгогчдын саналыг татах зорилгоор: 16.1. бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдсан, аливаа үйлчилгээг хөнгөлөлттэй болон төлбөргүйгээр үзүүлсэн, 16.2. нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, даяллага, цайллага, хонжворт сугалаа зохион байгуулсан, ивээн тэтгэсэн, 16.3. сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулсан, амралт, сувилалд амраасан, сувилуулсан, 16.4. ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулсан, хэлцэл хийсэн, 16.5. хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэргээр бусдад давуу байдал олгосон, амлалт өгсөн; 16.6. сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулсан; |
| 14.8.1. Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан ... | 17.1.7. Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол ... |

²⁷ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль 1.8.7 Эрүүгийн хэргийн шүүх Зөрчлийн тухай хуулийн ..., 17.1 дүгээр зүйлийн 7, 16 дахь хэсэг, 18.1, 18.2, 18.4 дэх заалт, 23 дахь хэсэг, 17.2 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулна.

Сонгуулийн хууль зөрчиж байгаа аливаа үйлдэл нь сонгуулийн үр дүнд ямар нэг хэмжээгээр хууль бусаар нөлөөлөх тодорхой зорилготой байдаг. Үүнийг холбогдох гэмт хэргээс ялган зүйлчлэхдээ, зөрчлийн шинж нь гэмт хэргээс хор уршиг, учруулсан хохирлын хэмжээгээр бага байх, ялимгүй байх зэрэг нөхцөлүүдийг анхаарч үзэх шаардлагатай. Жишээлбэл, *“УИХ-ын сонгуулийн 15-р тойргийн хорооны ухуулагчид Г, Ч нарт Н, М нарыг дэмжээрэй гэж 100,000 төгрөг өгсөн, иргэдэд сүү, 5000 төгрөг өгсөн”* хэрэг гарчээ. Энэ хэргийг цагдаагийн байгууллагаас зөрчил гэж үзэж, торгууль оногдуулжээ²⁸. Гэтэл, ЭХТА-ийн 14.5. Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх, гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн 2.3-д сонгогчийг эд хөрөнгө, мөнгөөр татаж санал худалдан авч үйлдсэн нөхцөл тогтоогдож байна.

Энэ тохиолдолд гэмт хэрэг эсхүл зөрчил эсэхийг ялган зүйлчлэхдээ, сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй тул заавал хор уршиг учирсан байхыг шаардахгүй бөгөөд харин ялгагдах гол шинжийн тухайд субъектив талын буюу иргэний сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд бодитой саад учруулах үйлдлээ ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн, мөн объектив талын нэмэгдэл шинж цаг үе, нөхцөл байдлыг харгалзан үзэх зохицуулалттай байна. Өөрөөр хэлбэл, сонгогч саналаа чөлөөтэй өгөх эрхэд хөндлөнгөөс хууль бус аливаа хэлбэрээр нөлөөлсний үр дүнд түүний өгсөн саналыг, өөрийнх нь хүсэл зоригийн жинхэнэ илэрхийлэл гэж үзэх боломжгүй нөхцөл байдал үүссэн буюу иргэн саналаа өгөхөөс өмнө худалдсан байх нөхцөлийг тогтоох тухай юм. Хэдийгээр, дээрх зөрчил нь сонгогч саналаа өгөөгүй байснаар буюу санал худалдаж аваагүй гэж үзэж зөрчилд тооцсон байх боломжтой ч ингэж эд зүйл, мөнгө тараасан нь ЭХТА-ийн 14.9 Сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх зорилгоор иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх гэмт хэрэг (ЭХТА 14.5)-т бэлтгэсэн, зохион байгуулсан гэмт хэргийн шинжтэй байна.

Эд хөрөнгө, мөнгө тараасан маргаан сонгуулийн үеэр олон гардаг²⁹ бөгөөд, шинэ ЭХ хэрэгжиж эхэлснээс хойш энэ төрлийн маргааныг гэмт хэрэгт тооцож шийдвэрлэсэн тохиолдолд байхгүй байгаа нь Зөрчлийн тухай хуулийн 17.1.16-д зааснаар шийдвэрлэж байж болзошгүй нөхцөл тогтоогдож байна. Шинэ ЭХ-иар, *“...эд хөрөнгө, мөнгөөр татаж санал худалдан авч үйлдсэн бол...”* гэсэн нөхцөл

²⁸ М.Эрдэнэбаяр, Д.Мягмарцэрэн, Г.Бямбадорж Я.Цэлмэн, Д.Сумъяацэрэн, Э.Золбоо, Монгол Улсад сонгууль зохион явуулахтай холбоотой гардаг гэмт хэрэг, зөрчлийг шалгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гарын авлага, УБ., 2016, 19 дэх тал;

²⁹ <https://ikon.mn/opinion/252p>

нь санал худалдан авах гэсэн аливаа үйлдлийг гэмт хэрэг биш зөрчил гэж үзэх нөхцөлийг бүрдүүлж, хууль зөрчигч этгээдэд ял завших, үйлдлээ илүү нарийн зохион байгуулалттай, нууц далд хэлбэрт шилжүүлэх боломжийг олгож байна. Учир нь сонгуулийн үеэр ямар ч хэлбэрээр сонгогчийн саналыг худалдаж авах гэсэн бай энэ нь сонгогчийн саналыг өөрийн эрх ашгийн талд нийцүүлэх гэсэн санаа зорилго тодорхой байдаг. Үүгээрээ гэмт хэргийн субъектив талын шинж бүрэн хангагдана. Гэвч эд зүйл, мөнгө тараасан нь сонгуулийн санал хураалтын өмнө цагдаагийн байгууллагад бүртгэгдэж, шалгагдаж эхэлсэн гэх зөвхөн энэ нөхцөлөөр зөрчил гэж үздэг практик тогтжээ.

2.3 Гэмт хэрэгт оногдуулах ял, ялын бодлого

Эрүүгийн эрх зүй нь гэмт хэрэг – ял30 гэсэн хоёр ухагдахуунд суурилдаг бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл нь гэмт хэрэг үйлдсэн байх явдал бол ЭХТА-д ял оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэгт тооцогддог.

Эрдэмтэд, судлаачид ялын олон сонголттой, уян хатан байхыг дэмждэг ба шинэ ЭХ-иар сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ялын төрлийг нэмж торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих үндсэн, эрх хасах ялыг нэмэгдэл ял болгон оногдуулахаар заажээ.

ХҮСНЭГТ 11. СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТ ОНОГДУУЛАХ ЯЛЫН ТӨРӨЛ

| Зүйл анги | Торгох | Нийтэд тустай ажил хийлгэх | Зорчих эрхийг хязгаарлах | Хорих | Эрх хасах |
|-----------|--------|----------------------------|--------------------------|-------|-----------|
| 14.5 | + | + | + | + | |
| 14.6 | + | + | + | + | |
| 14.7 | + | | + | + | |
| 14.8 | + | + | + | + | + |
| 14.9 | + | | | + | |

Хэдийгээр ялын олон сонголттой байх нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжих, дахин нийгэмшихэд дэмжлэг үзүүлдэг давуу талтай боловч тухайн гэмт хэргийн онцлог байдалд тохироогүй буюу ялын бодлого чанга байх, гарцаагүй байх шинж чанарыг орхигдуулж болох эрсдэлтэй байна.

Гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд нь тухайн ялыг эдэлснээр дахин гэмт хэрэг үйлдэхгүй болж ахуйн дунд буюу цаарлал болж энэ жилээр өөр бусад этгээдэд ял гэдэг нь гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх, эрх үйлдвэрийг эсэргүүцэн үйлдэх буюу цаарлал болж өөр бусад этгээдэд ял албадлагын арга хэмжээ.

энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхээс татгалзсанаар эрүүгийн хариуцлагын зорилго³¹ хангагдах учиртай.

ХҮСНЭГТ 12. ЯЛЫН ЗОРИЛГО, ЦЭЭРЛЭЛ, ХЭМЖЭЭ

| № | Ялын төрөл/зорилго, цээрлэл | Ялын хэмжээ | Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт: |
|----|---|---------------------|--------------------------------------|
| 1. | Торгох (14.5.1, 14.5.2, 14.6.1, 14.6.2, 14.7.1, 14.8.1, 14.8.2, 14.9.1) Ялтны эд хөрөнгийн эрхийг хязгаарлах замаар түүнд эдийн засгийн дарамт, таагүй үр дагавраар нөлөөлж, эргэж төлөгдөх нөхцөлгүйгээр мөнгөн төлбөрийг шүүхийн шийдвэрээр албадан төрийн өмчлөлд шилжүүлэх; | 100-40'000 нэгж | 450-40'000 нэгж |
| 2. | Нийтэд тустай ажил хийлгэх (14.5.1, 14.6.1, 14.8.1) Ялтанг гэмт хэрэг үйлдсэний улмаас эрх чөлөөгөө хязгаарлуулсан байдал, бие махбод, сэтгэл санааны дарамт, цээрлэлийг ойлгуулж мэдүүлэх, бусдыг хүндэтгэж, хууль ёс, дэг журмыг сахин биелүүлдэг болгон хүмүүжүүлэх, амьдралд нь хэрэгтэй ажил хөдөлмөрийн дадал, туршлага эзэмшүүлэх, хүмүүжүүлэх замаар дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх; | 240-720 цаг | 240-720 цаг |
| 3. | Зорчих эрхийг хязгаарлах(14.5.1, 14.5.2, 14.6.1, 14.6.2, 14.7.1, 14.8.1, 14.8.2) Ялтныг нийгмээс тусгаарлахгүйгээр зүй зохистой, зөв амьдралд ороход туслалцаа үзүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэх зан үйлээс нь татгалзуулах, урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хохирогч бусад хүнийг хамгаалахад оршино. | 1 сараас 5 жил | 1 сараас 5 жил |
| 4. | Хорих (14.5.2, 14.6.2, 14.7.1, 14.8.2, 14.9.1) Ялтны чөлөөтэй зорчин явах эрхийг шууд хязгаарлан олон нийтээс тусад нь хорих байгууллагад байлгаж байгаатай холбогдон тодорхой эрхээс бусад иргэний эрхийг хасах буюу хязгаарлах; | 6 сараас бүх насаар | 6 сараас 8 жил |
| 5. | Эрх хасах (14.8.2) Нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл тодорхой эрхийг хуульд заасан хугацаагаар хориглоно. | 1-8 жил | 1-3 жил |

Манай улс хэт олон хоригдолтой болсон гэдэг үндэслэлээр шинэ ЭХ-иар ялын бодлогыг зөөлрүүлсэн нь сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт ч мөн адил үйлчилж нэг гэмт хэрэгт 3-4 ялын төрлөөс сонгох боломжтой байхаас гадна ялын хэмжээний хувьд хөнгөн байхаар хуульчилжээ. Мөн нэмэгдэл ялыг ³¹ Эрүүгийн хуулийн 5.3 дахь хэсэгт зааснаар нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.

зөвхөн 1 хэрэгт буюу сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн (ЭХТА-14.8.2)-д оногдуулахаар хуульчилсан байна.

Ялын хэмжээний харьцуулалтыг, сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах хорих ялын өөрчлөлтийг 2002 он, 2015 оны ЭХ-ийн тодруулж үзлээ.

ХҮСНЭГТ 13. СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ЯЛЫН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ (ХОРИХ ЯЛ)

| 2002 оны ЭХ | | | | 2015 оны ЭХ | | | | Өөрчлөлт | |
|------------------|---------------------|-------------|-------------|-------------|---------|-------------|-------------|-------------|-------------|
| Зүйл, хэсэг | Ангилал | Доод хэмжээ | Дээд хэмжээ | Зүйл, хэсэг | Ангилал | Доод хэмжээ | Дээд хэмжээ | Доод хэмжээ | Дээд хэмжээ |
| 130 | Хөнгөн/хүндэвтэр | | | 14.5.2 | Хөнгөн | 1 жил | 5 жил | +1 жил | +5 жил |
| 130 ¹ | Хүндэвтэр | | | 14.6.2 | Хөнгөн | 1 жил | 5 жил | +1 жил | +5 жил |
| 131 | Хүндэвтэр | | | 14.7 | Хөнгөн | 1 жил | 5 жил | +1 жил | +5 жил |
| "111" | Хүндэвтэр | 2 жил | 5 жил | 14.8.2 | Хөнгөн | 6 сар | 2 жил | -1,6 жил | -3 жил |
| 82 ¹ | Хүнд | 5 жил | 10 жил | 14.9 | Хүнд | 2 жил | 8 жил | -3 жил | -2 жил |
| | Онц хүнд гэмт хэрэг | 16 жил | 25 жил | | | | | -14 жил | -23 жил |

Хүснэгтээс үзэхэд, шинэ ЭХ-ийн зохицуулалтаар баривчлах ял хасагдсанаас сонгуулийн эрхийн эсрэг ихэнх гэмт хэрэгт хорих ял оногдуулахаар заажээ. Ихэнхдээ хорих ялын хэмжээ 1-5 жил хүртэл хугацаатай байгаа нь 1-ээс бусад нь "хөнгөн"³² гэмт хэргийн ангилалд багтаж байна.

Хөнгөн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байхаар зааснаас гадна хорих ялаас чөлөөлөгдөх, хөнгөрүүлэх боломжтой юм. ЭХ-д гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, чөлөөлөх, албадлагын арга хэмжээг хэрэглэх нөхцөлийг заасан. Энэ нөхцөлийг сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт хэрэглэгдэх байдлыг харьцуулахад, 1 (14.8) хэрэгт хорих ялаас чөлөөлөх, 3 хэрэгт тэнсэх, 1 хэрэгт хөнгөрүүлэх боломжтой байна.

2.2.3. Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт шүүхээс ял оногдуулж буй практик

Энэ төрлийн гэмт хэрэгт шүүхээс торгох ял оногдуулж буй практик дийлэнх байна. Ял шийтгэсэн 8 гэмт хэргийн 6-д нь 7'100'000-12'700'000 төгрөгийн

³² Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ.

хооронд торгох ял оногдуулсан ба торгуулийн дундаж хэмжээ 10'459'800 (10'000 нэгж) төгрөг байна. Харин шинэ ЭХ-ийг хэрэглэж шийдвэрлэсэн ердөө 2 хэрэг байгаа бөгөөд хорих болон зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулжээ.

ХҮСНЭГТ 14. СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТ ШҮҮХЭЭС ОНОГДУУЛСАН ЯЛЫН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭ

| № | Шийтгэх тогтоолын дугаар | Зүйлчлэл | Ялын төрөл | Ялын хэмжээ |
|----|---|----------|-----------------------|-------------|
| 1. | БГД дэх ЭХАШШ 2012.07.27 №331 | 111.1 | Торгох | 9'828'000 |
| 2. | БГД дэх ЭХАШШ 2012.12.04 №483 | 130.2 | Торгох | 12'636'000 |
| 3. | БГД дэх ЭХАШШ 2012.12.10 №491 | 130.2 | Торгох | 12'636'000 |
| 4. | Завхан аймаг дах Сум дундын II шүүх 2013.04.16 №12 | 130.2 | Торгох | 10'530'000 |
| 5. | Хөвсгөл аймаг дах Сум дундын шүүхийн Эрүүгийн шүүх 2013.05.08 №72 | 130.2 | Торгох | 9'968'400 |
| 6. | Орхон аймаг дах Сум дундын шүүхийн Эрүүгийн шүүх 2013.11.15 №0148 | 111.2 | Торгох | 7'160'400 |
| 7. | БГД дэх ЭХАШШ 2019.10.31 №902 | 14.9.1 | Хорих | 4 жил |
| 8. | Хөвсгөл аймаг дах Сум дундын ЭХАШШ 2021.10.25 №2021/ШЦТ/152 | 14.7.1 | Зорчих эрх хязгаарлах | 1 жил |

Аливаа ял нь гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ, шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруу, хувийн байдалд тохирсон байх учиртай.³³ Иймээс ял шийтгэлийн төрлөөс гадна ялын дээд, доод хэмжээ, ялын тохироо, ялаас чөлөөлж, хөнгөрүүлж буй үндэслэл, оновчтой байдал, ялын хэрэгжилт, хамгийн чухал нь ялын үр нөлөө юу байна вэ гэдэг нь гол шалгуур үзүүлэлт болох юм.

Сонгуулийн эрхийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн дийлэнх нь санал худалдаж авч үйлдсэн буюу мөнгө, эд хөрөнгөтэй холбоотой байгаа юм. Тэгвэл энэ төрлийн гэмт хэрэгт ихэнхдээ торгох ял оногдуулж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт нийцэж байгаа эсэх, торгуулийн хэмжээ нь торгох ялын зорилгод нийцэж байгаа эсэх болон тус төрлийн ялын үр нөлөө хэр байгааг тодруулах шаардлагатай байна.

2022 оны байдлаар манай улс авлигын индексээр 180 улсаас 116-д жагссан ба энэ үзүүлэлтийн 5 гол шалгуур нь Хээл хахууль, Улсын болон орон нутгийн төсвийг хууль бусаар захиран зарцуулсан байдал, Хувийн ашиг сонирхолдоо

³³ С.Гантулга, Б.Энхболд “Эрүүгийн эрх зүй: Тусгай анги” сурах бичиг, УБ., 2021

нийцүүлэн эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашигласан байдал, Хувийн ашиг сонирхлын үүднээс корпорац компаниуд зэрэг бүлэг этгээдүүд төрийн өндөр албан тушаалтнуудад авлига өгч өөрийн ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргуулах, Төрийн албан хаагчдын дунд танил тал, найз нөхөд албан тушаалтны шахалт зэрэг төрийн албан дах авлигын асуудлыг авч үздэг.³⁴ Бодит байдалд, манай улс төр, нийгмийн амьдрал төрийн эрх мэдэл, албан тушаалын байдлаас шууд хамаарч, авлигын нөхцөл байдал сайжрахгүй байна. Гэтэл энэ эрх мэдлийн төлөөх шударга бусаар өрсөлдсөн гэмт хэрэгт торгох ял оногдуулж байгаа нь хэр нийцтэй байна вэ?. Үүнээс гадна, оногдуулж буй торгох ялын хувьд дунджаар 10'000'000 төгрөгийн торгууль оногдуулж байна. Энэ нь гэм буруутай этгээдэд эдийн засгийн дарамт, таагүй үр дагавраар нөлөөлж, цээрлэл болж чадаж байгаа нь эргэлзээтэй байна. Бодит нөхцөл, байдалтай холбон үзвэл, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж торгох ялаар шийтгүүлсэн этгээд ялангуяа өөрийнх нь ажилласан нэр дэвшигч ялалт байгуулсан тохиолдолд, тухайн мөнгийг нэр дэвшигчээс гаргуулах, нэр дэвшигч болон өөрөө торгуулийн төлбөрийг авилгаас бүрдүүлэх эрсдэлтэй.

Шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлуудаас, анх удаа гэмт хэрэг үйлдсэнээс өөр эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл тогтоогдохгүй байгаа бол, гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн хүндрүүлэх нөхцөл ихэнх гэмт хэрэгт тогтоогдож байна.

Иймд, сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ялын асуудалтай холбогдуулан анхаарах шаардлагатай дараах нөхцөлүүд байна. Үүнд:

1. Санал худалдан авсан гэмт хэрэгт торгох ял оногдуулж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн онцлог байдлыг харгалзан үзээгүй, гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ, шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруу, хувийн байдалд тохироогүй байна. Мөнгөтэй этгээдэд мөнгөн торгууль оногдуулах нь торгох ялын зорилго, цээрлэлийг хангаж чадахгүй.
2. Зорчих эрх хязгаарлах ялыг сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулахаас бусад энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах боломжтой байхаар заасан. Зорчих эрх хязгаарлах ял нь хулгай, дээрэм зэрэг гэмт хэргийн хувьд үр нөлөө өндөр байж болох ч сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах нь үр нөлөө багатай байж болзошгүй. Тухайлбал, зорчих эрх хязгаарлах ялын хэмжээ нь ээлжит сонгууль хоорондын хугацаанаас

³⁴ <https://www.transparency.org/en/press/2022-corruption-perceptions-index-neglect-anti-corruption-efforts-asia-pacific>

бага байхаас гадна, зорчих эрх хязгаарлах ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж болох зохицуулалттай байгаа нь энэ гэмт хэргийн шийдвэрлэлт ихсэх тохиолдолд үр нөлөөтэй эрүүгийн хариуцлага болж чадах эсэхэд дүгнэлт хийх шаардлагатай.

3. Нэмэгдэл ялын тухайд, нийтийн албанд ажиллах ёс зүйн хэм хэмжүүрийн үүднээс энэ төрлийн гэмт хэрэгт эрх хасах ялыг нэмэгдэл ялаар оногдуулах, торгох ялаар шийтгүүлээд, төрийн албанд томилогддог байдлаас сэргийлж нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хүртэл хасах ял оногдуулдаг болох нь ач холбогдолтой байна.

2.4 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практик

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх явдал багтдаг. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулах нь чухал боловч нөгөө талаас эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсний үр дүнд хохирогчийн зөрчигдсөн эрх сэргэсэн байх явдал мөн чухал юм.

ЭХХША-ны практик нь гэмт хэргийг илрүүлэх, шалгах, шийтгэх гэсэн ажиллагаагаар хийгддэг бөгөөд зөрчигдсөн эрх сэргээх болон эрх зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтийн асуудлыг ЭХХША-аас тусад нь салгаж авч үздэг зохимжгүй практик манай улсад нийтлэг байдаг. Энэ байдал сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийг шалган шийдвэрлэх ажиллагааны практикт ч мөн орхигдсон дүр зураг ажиглагдлаа. Тухайлбал, шүүхээр шийдвэрлэсэн хэргүүдэд, хохирогчоор тогтоосон ч хохирогчийн гомдлын хүрээнд эрх сэргээхэд анхаарал хандуулаагүй, хохирогчийн нэхэмжлэлийг шалган шийдвэрлээгүй орхигдуулсан байна.

Шүүхээр шийдвэрлэсэн хэргээс 6 хэрэгт нийт 8 иргэнийг хохирогчоор тогтоосон. Хохирогчдын тухайд, бүгд сонгуульд нэр дэвшиж оролцсон бөгөөд гэмт хэргийн улмаас сонгогдох эрх нь зөрчигдсөн тул уг эрхийг сэргээж өгөхийг хүссэн байдаг. Хэрэг шийдвэрлэлтээс харахад, гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож байгаа ч, хохирогчдын эрхийг сэргээхэд анхаарсан шийдвэр байхгүй байна.

2002-2022 оны хагас жилийн байдлаар шүүхээс сонгуулийн эрх зөрчсөн дараах 10 гэмт хэргийг хянан шийдвэрлэж, 2 хэрэгт цагаатгах, 8 хэрэгт шийтгэх тогтоол гаргажээ.

ХҮСНЭГТ 15. ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ(ОН ЦАГИЙН ДАРААЛЛААР)

| № | Шийдвэрийн дугаар, огноо | Хэргийн товч утга | Оногдуулсан ял шийтгэл |
|----|--|--|---|
| 1. | Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2012.07.27 өдөр Дугаар: 331 Шийтгэх тогтоол | Шүүгдэгч Б нь 2012.05.21-ний өдрийн “Улс төрийн тойм” сонины дугаарт УИХ-ын гишүүн, УИХ-д нэр дэвшигч “О-н сонгуулийн нууц төлөвлөгөө задрал” сэдвээр нийтлэл гаргаж, нэр дэвшигч О-г худал гүтгэж, нэр төрийг гутаасан. | 9’828’000(есөн сая найман зуун хорин найман мянга) төгрөгөөр торгосон. |
| 2. | Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2012.12.04 өдөр Дугаар: 483 Шийтгэх тогтоол | Шүүгдэгч Ж,Г,Л нар нь бүлэглэн 2012 оны УИХ-ын сонгуульд МАН-аас нэр дэвшигч Ч, Х нарт санал өгүүлэх зорилгоор тус тойргийн 8 иргэнд түрээсийн гэрээ байгуулж тус бүр 100’000, нийт 800’000 төгрөг тараасан. | 12’636’000(арван хоёр сая зургаан зуун гучин зургаан мянга) төгрөгөөр торгосон. |
| 3. | Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2012.12.10 өдөр Дугаар: 491 Шийтгэх тогтоол | Шүүгдэгч Ч, Б нар нь бүлэглэн 2012 оны УИХ-ын сонгуульд МАН-аас нэр дэвшигч Ч, Х нарт санал өгүүлэх зорилгоор “Гэрийг нь түрээслэх” нэрээр гэрээ байгуулж, төлбөрт 150’000 төгрөг өгч, нийт 9 оюутанд мөнгө тараасан. | 12’636’000(арван хоёр сая зургаан зуун гучин зургаан мянга) төгрөгөөр торгосон. |
| 4. | Завхан аймаг дах сум дундын II шүүх 2013.04.16 өдөр Дугаар: 12 Шийтгэх тогтоол | Шүүгдэгч Э нь сумын ЗДТГ-ын орлогч бөгөөд 2012 оны УИХ-ын сонгуульд МАН-аас нэр дэвшигч Б, О нарт санал өгүүлэхээр 2’000-15’000 төгрөгийн А-80 бензинийг нийт 14 хүнд тараасан. | 10’530’000(арван сая таван зуун гучин мянга) төгрөгөөр торгосон. |
| 5. | Хөвсгөл аймаг дах сум дундын шүүхийн Эрүүгийн шүүх 2013.05.08 өдөр Дугаар: 72 Шийтгэх тогтоол | Шүүгдэгч Ш, Т нар нь бүлэглэн 2012 оны сумын ИТХ-ын төлөөлөгч сонгох сонгуульд нэр дэвшиж буй Т-д санал өгүүлэх зорилгоор санал өгөх иргэдэд 10’000, 20’000 төгрөг тараасан. (Нэр дэвшсэн Т ялалт байгуулсан байсан.) | Шүүгдэгч Т-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч Ш-г 9’968’400 төгрөгөөр торгосон. |

| | | | |
|-----|--|--|--|
| 6. | Хөвсгөл аймаг дах Сум дундын шүүхийн Эрүүгийн шүүх 2013.06.11 өдөр Дугаар: 0093 Цагаатгах тогтоол | Шүүгдэгч Э нь сумын ЗДТГ-т ажилладаг бөгөөд, 2012 онд сонгуулийн хорооны даргын үүргийг гүйцэтгэж байхдаа Аймгийн ИТХ-ын сонгуульд бие даан нэр дэвшсэн Б-ийн эсрэг түүний дэмжигчдийн өмнөөс өргөдөл гаргаж, гарын үсгийг дуурайж зурж, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн. | Гэмт хэргийг үйлдсэн гэх үндэслэлгүй. Шүүгдэгч Э-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгасан. |
| 7. | Орхон аймаг дах Сум дундын шүүхийн Эрүүгийн шүүх 2013.11.15-ны өдөр Дугаар: 0148 Шийтгэх тогтоол | Шүүгдэгч, Ж.Э, Ч.Э нар нь 2012 оны Аймгийн ИТХ-ын сонгуульд АН-аас нэр дэвшигч О-г "малчдад хивэг тараасан" гэж орон нутгийн Номин, Тусгал зэрэг телевизүүдээр илт худал гүтгэлгийг олон нийтэд тараасан. | Шүүгдэгч тус бүрт 7'160'400(долоон сая нэг зуун жаран мянга дөрвөн зуу) төгрөгөөр торгох ялаар тус тус шийтгэсэн. |
| 8. | Баян-Өлгий аймаг дах Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2016.08.30 өдөр Дугаар: 043 Цагаатгах тогтоол | Шүүгдэгч А, Е нар нь 2015 онд зохион байгуулагдсан Тосгоны захирагчийн сонгуульд нэр дэвшсэн Е-д санал өгүүлэх зорилгоор, иргэдэд 100'000-300'000 төгрөгийг тараасан. (Нэр дэвшсэн Е нь тус сонгуульд ялалт байгуулсан байсан.) | Гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэл нь цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нийгэмд аюултай шинж чанараа алдсан гэж дүгнэж, хэрэгсэхгүй болгож цагаатгасан. |
| 9. | Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2019.10.31 өдөр Дугаар: 902 Шийтгэх тогтоол | Шүүгдэгч С, Г нар нь бүлэглэн 2014 онд төрийн албан тушаалыг мөнгөөр үнэлж, бохир технологи ашиглах, тусгай ажиллагааны баг байгуулж, судалгаа хийлгэн ажиллуулсан, түүнийгээ бусдад танилцуулах, хэрэгжих боломжийг эрэлхийлэх үйлдлийг гүйцэтгэн, төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулсан. | ЭХ-н 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг болгон өөрчлөн зүйлчилж, Шүүгдэгч Г, С нарт тус бүр 4 жилийн хорих ял, нээлттэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн. |
| 10. | Хөвсгөл аймаг дах Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2021.10.25 өдөр Дугаар: 2021/ ШЦТ/152 Шийтгэх тогтоол | Шүүгдэгч Б нь 2018 оны сонгуулийн нэгдсэн хорооны даргаар ажиллахдаа Тосгоны захирагчийн сонгуулийн үр дүнг танилцуулахдаа хүчингүй 41 саналын хуудсыг нийт саналаас хасаж, хорооны гишүүд, нарийн бичгийн дарга нарт буруу мэдээлэн, сонгуулийн санал хураалтын дүнг өөрчилсөн. | 1 жил зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэж, өршөөлийн хуульд хамруулж эрүүгийн хэргийг өршөөн хэрэгсэхгүй болгож, ялаас хэлтрүүлсэн. |

Дээрх хэргүүдийг шүүхээр хянан шийдвэрлэхэд, шинжлэн судлуулсан нотлох баримт, хохирогч, гэрчийн мэдүүлэг болон шүүхийн шийдвэрт өмнө дурдсан хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх асуудлаас гадна дараах нөхцөлүүдийг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

1. Гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэрийг авч үзсэн байдал: Дээрх 10 хэргээс 6 хэрэгт нь гэмт хэргийн бүлэглэн үйлдсэн нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнээс 2 хэрэгт, нэр дэвшиж ялалт байгуулсан холбогдогчид холбогдох үйлдлийг цагаатгаж шийдвэрлэсэн. Хэдийгээр энэ төрлийн гэмт хэрэгт “бүлэглэн” үйлдсэнийг хүндрүүлэх бүрэлдэхүүнээр зүйлчлэн зохицуулаагүй боловч ЭХ-ийн ерөнхий ангийн эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөлд “гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн”-г шүүх эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ харгалзах зохицуулалттай³⁵. Гэвч зарим хэргийг шийдвэрлэхдээ үүнийг харгалзаагүй.
2. Тээврийн хэрэгсэл ашигласан эсэх: Сонгогчдод мөнгө тараасан гэмт хэрэг үйлдэхдээ тээврийн хэрэгсэл ашиглаж үйлдсэн нөхцөл байдал 3 гэмт хэрэгт тодорхой байна. ЭХ-д “гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, ..., тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэхэд зарцуулна”³⁶ гэж заасан. Мөрдөн шалгах ажиллагааны шатанд 2 тээврийн хэрэгслийг битүүмжилсэн байсан ч шүүхийн шатанд “гэмт хэрэг үйлдэхдээ тээврийн хэрэгсэл ашигласан”-ыг анхаарч үзээгүй, битүүмжийг цуцалжээ.
3. Хохирогчоор тогтоосон эсэх: Шүүхээр шийдвэрлэсэн зарим хэрэгт, гэмт хэргийн улмаас өөрийнх нь эрх ашиг зөрчигдсөн талаар мэдүүлэг өгсөн хүнийг хохирогчоор тогтоогоогүй. Зөвхөн гэрчийн мэдүүлэг авч шалгасан.
4. Нотолгооны асуудал: Шүүгдэгчийг цагаатгасан гэмт хэргүүдэд, түүнд хамаарах үйлдлийг зөвхөн “гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийн мэдүүлэг”-т үндэслэн шийдвэрлэсэн байдал ажиглагдлаа. Тухайлбал, нэр дэвшигчдийн өмнөөс хэрэг хүлээх, “би сайн дураараа туслах гэсэн, нэр дэвшигч өөрөө мэдээгүй”, “би мэдээгүй, надад буруу байхгүй, би мөнгө тараасан, тараагаагүй ялах байсан” гэж мэдүүлсэн байдаг. Гэтэл, нэр дэвшигчийг өөрөө хүсээгүй байхад нь өмнөөс нь мөнгө тарааж, эрсдэл хүлээх сонирхол хэнд байх вэ зэрэг шалтгаант холбоог тодруулаагүй, нотлоогүй өнгөц хандсан. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийн дахин гэмт хэрэг үйлдэх хамгийн

³⁵ Эрүүгийн хууль, 2015 он, 6.6. Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл, 1.1.2 дахь хэсэг;

³⁶ Эрүүгийн хууль, 2015 он, 7.5. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ 7.5.4 дэх хэсэг;

тааламжтай нөхцөл бол анхных нь хэрэг илрэхгүй, уг үйлдсэн хэрэгтээ эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх явдал³⁷ бөгөөд сонгогчийн саналыг худалдан авч ялалт байгуулсан жинхэнэ этгээдийн үйлдлийг нотолж чадахгүй орхигдуулснаар дараагийн сонгуульд энэ үйлдлээ давтах магадлал өндөр,

5. Хууль хэрэглээ: Цагаатгасан хэргийн тухайд, төсөөтэй хэрэгт шүүхүүд харилцан адилгүй шийдвэр гаргасан буюу сонгогчийг саналыг худалдаж авсан үйлдлийг ихэнх хэрэгт ял оногдуулсан байгаа бол нэг хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, цагаатгасан байна. Ингэж цагаатгасан үндэслэлээ, “шүүгдэгч нар нь ... иргэний сонгох эрхээ хэрэгжүүлэхэд эд мөнгөөр татах аргаар саад хийсэн, санал худалдан авах үйлдэл хийсэн нь нотлогдон тогтоогдож байгаа боловч ... шинээр хэрэгжиж байгаа Сонгуулийн тухай хуулиар дээрх үйлдлийг нарийвчлан оруулж зохицуулсан байх тул захиргааны зөрчил гэж үзэх бүрэн үндэстэй байна гэж үзлээ” гэжээ. Энэ нь хуулийн зохицуулалтыг буруу тайлбарлан хэрэглэснээс гадна, тухайн шүүх өөрийн санал худалдан авсан үйлдлийн хуулийн зохицуулалтын талаар нэг мөр ойлголтгүй байгаа асуудлууд байна.

Төсөөтэй хэргүүдэд өөр, өөр шийдвэр гаргасныг дараах хүснэгтэд харьцуулан үзүүлээ.

ХҮСНЭГТ 16. ТӨСӨӨТЭЙ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

| Агуулга | Кейс №05 | Кейс №08 |
|---------------|--|--|
| Хэргийн товч | Ш, Т нар нь бүлэглэн 2012 оны сумын ИТХ-ын төлөөлөгч сонгох сонгуульд нэр дэвшиж буй Т-д санал өгүүлэх зорилгоор иргэдэд 10'000, 20'000 төгрөг тараасан. | А, Е нар нь 2015 онд зохион байгуулагдсан Тосгоны захирагчийн сонгуульд нэр дэвшсэн Е-д санал өгүүлэх зорилгоор, иргэдэд 100'000-300'000 төгрөгийг тараасан. |
| Хэрэглэсэн ЭХ | 2002 оны ЭХ | 2002 оны ЭХ |
| Зүйлчлэл | 130.2 | 130.2 |

³⁷ Б.Батзориг, Нотолгооны онол, гарын авлага, УБ., 2013,


| | | |
|----------------------|---|---|
| Шийдвэрлэсэн байдал: | Шийтгэсэн. Шүүгдэгч Т-тэй холбогдох үйлдэл нь нотлох баримтаар хангалттай нотлогдохгүй байна гэж үзэж хэрэгсэхгүй болгосон. Харин шүүгдэгч Ш нь шүүх хуралдааны үеэр өөрийн гэм бурууг хүлээн зөвшөөрсөн болон хэрэгт цугларсан нотлох баримтаар Ш нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болох нь тогтоогдож байх тул түүнд ЭХ-ийн 130 дугаар зүйлийн 130.2-т заасан Иргэний сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд саад хийн эд мөнгөөр татах, санал худалдаж авсан гэмт хэргийг үйлдсэн тул, торгох ялаар шийтгэжээ. | Хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгасан. шүүгдэгч А, Е нар нь иргэний сонгох эрхээ хэрэгжүүлэхэд эд мөнгөөр татах аргаар саад хийсэн, санал худалдан авах үйлдэл хийсэн нь нотлогдон тогтоогдож байна. ... Шүүгдэгч нарын гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэл нь цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нийгэмд аюултай шинж чанараа алдсан байна. Учир нь 2016.12.25-ны өдөр батлагдан хэрэгжиж эхэлсэн Сонгуулийн тухай хуулийн 70-р зүйлийн 70.1.1-д “мөнгө, эд зүйл тараах”, ...70.5.16-д “сонгогчдын санал худалдан авахад чиглэсэн бусад аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулах” заалтуудаар дээрх үйлдлийг нарийвчлан оруулж зохицуулсан байх тул захиргааны зөрчил гэж үзэх бүрэн үндэстэй байна. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 531 дүгээр зүйлийн 531.1-д зааснаар “МУИХ-ын, Ерөнхийлөгчийн, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн болон ард нийтийн санал асуулгын тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэх асуудлыг эдгээр холбогдох хуульд зааснаар зохицуулна” гэж заасан байна. Иймд хэргийг хэрэгсэхгүй болгон, шүүгдэгчдийг цагаатгаж шийдвэрлэжээ. |
| Төсөөтэй байдал: | Нэр дэвшигч өөрөө хэрэгт холбогдсон. Тухайн сонгуульд ялалт байгуулж, сонгогдсон. | |
| Анхаарах асуудал: | Нэр дэвшигчтэй гэмт хэрэгт хамтран оролцсон этгээдийн гэм бурууг өөртөө хүлээсэн байдал. | Шүүгчдийн мэдлэг, ойлголт: Хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэх асуудал. Мөнгө тарааж, сонгуульд ялалт байгуулсан. |

2.4.1 Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэх хугацаа

Сонгууль зохион байгуулагдах хугацаанд болон сонгуулийн үе шатанд багтаан сонгуультай холбоотой эрх зүйн зөрчил, маргааныг хянан шийдвэрлэх нь ач холбогдолтой болох нь сонгуулийн тогтолцооны асуудалтай хамт хөндөгддөг. Хэрэв энэ хугацаанд хэргийн талаар шийдвэр гараагүй бол иргэний зөрчигдсэн сонгуулийн эрхийг сэргээх боломжгүй болдог. Практикт, Эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэлх хугацаа хамгийн ихдээ 543 хоног буюу 2 жил

орчим байхаар харагдаж байна. Үүнээс гадна шүүхээс яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа гэх мэт анхан шатны шүүх хуралдааныг зарлах хүртэл мөн 2 сар орчим хугацаа байх боломжтой байдаг.

ЭХХШТХ-ийн 44.2 дах хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаа нь дараах байдлаар тогтоогдсон байдаг.



Одоогийн нөхцөлд хуулийн хугацааны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэнээр, сонгуулийн хугацаа өнгөрмөгц гомдол, мэдээлэл гаргагчийн хэрэг хянан шийдвэрлүүлэх идэвх оролцоо буурах, гомдлоосоо татгалзах нөхцөл байдлыг үүсгэхээс гадна, нэгэнт сонгуулийн үр дүн гарсан бол зөрчигдсөн эрх сэргээх боломжгүй болж, сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэх аль аль талдаа ач холбогдолгүй болж байна. Тухайлбал, судалгаанд ашигласан, шүүхээр шийдвэрлэсэн 10 хэрэг нь хэрэг явдал болсон цаг хугацаанаас хойш хамгийн багадаа 2 сар, хамгийн ихдээ 63 сарын дараа шийдвэрлэсэн тохиолдлууд байна. Эдгээр шүүхээр шийдвэрлэсэн хэргүүдээс сонгогдогчийн эрх зөрчсөн хэргийн шийдвэрлэлтийг сонгуулийн хугацаатай харьцуулан авч үзвэл, “сонгогдох эрх зөрчсөн гэж мэдүүлсэн 6 хэрэг нь бүгд сонгуулийн хугацаанд шийдэгдээгүй байх бөгөөд, зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбогдуулан шүүхийн шийдвэрээр ямар нэг дүгнэлт гаргаагүй байна.

ХҮСНЭГТ 17. СОНГОГДОХ ЭРХ ЗӨРЧИГДСӨН ТАЛААРХ ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ГАРГАГЧДЫН МЭДҮҮЛЭГ

Кейс 1: Хохирогч Ч-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэг: “...Би 2012 оны орон нутгийн сонгуульд Мөрөн сумын 7 дугаар багт Ардчилсан намаас нэр дэвшсэн юм. Тэгээд орой 20 цаг 30 минутын өмнө мөнгө тарааж байна гэсэн мэдээлэл ирсэн. ...Удалгүй цагдаа нар машин саатуулсан байсан. Тэр машин хххх УАӨ гэсэн дугаартай машин байсан. ...7 дугаар багт нэр дэвшсэн бусад хүмүүс бэлэн мөнгө тарааж иргэдийн сонгох эрхэнд халдан тэдний саналыг мөнгөөр худалдан авсан үйлдэл тогтоогдсон гэж бодож байгаа бөгөөд энэ нь миний сонгогдох эрхийг зөрчсөн. Иймд сонгогдсон хүмүүсийг эргүүлэн бидний зөрчигдсөн эрхийг сэргээж өгнө үү”.

Кейс 2: Хохирогч Б-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэг: "...би 2012 оны орон нутгийн сонгуульд аймгийн ИТХ-д бие даан нэр дэвшихээр болоод 563 хүний гарын үсэг цуглуулах болсон. Ингээд сумын 1,2,3,4,5 дугаар багийн оршин суугчид хамаарч байсан тул дээрх тооны гарын үсэг зуруулан аймгийн сонгуулийн хороонд хүргүүлсэн... Э нь хуурамч бичиг баримт бүрдүүлснээс болоод...миний нэр дэвших эрхийг хааж боогдуулсан. Хэрвээ би нэр дэвшсэн бол гарах магадлал өндөр байсан. Би сонгуульд нэр дэвших гэж сурталчилгааны материал хэвлүүлсэн, захиргааны хэргийн шүүхэд хандаж Мөрөн, Жаргалант сумын хооронд явсан зардал, хөдөө гадаа явсан зардал, гээд зардал их гарсан, сонгуулиас хасагдаж нэр хүнд их унасан, нэр төрөө сэргээлгэмээр байна..."

Кейс 3: Хохирогч О-ын мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэг: "...Би 2012 оны орон нутгийн сонгуульд АН-аас Орхон аймгийн ИТХ-дын төлөөлөгчид нэр дэвшсэн. Намайг сурталчилгааны ажилтай явж байхад МАН-ын төлөөлөл хэвлэлийн бага хурал хийж, ОН-ийн телевизүүдээр миний талаар худал мэдээлэл хийсэн. Энэ сөрөг мэдээлэл худлаа гүтгэлэг байсан бөгөөд энэ мэдээллээс болж би сонгуульд ялагдсан юм. Энэ мэдээллийг хуулийн байгууллагаар шалгуулаад үнэн мөнийг тогтоогоод иргэд нийтэд зарлах хугацаа байгаагүй юм. Сонгууль тулсан байсан учир ямар ч боломж гараагүй тэгээд сонгуулийн үр дүнд нөлөөлж би ялагдсан гэж үзэж байгаа. Намайг сонгуулийн хууль тогтоомж зөрчиж малын тэжээл тараагаагүй гэдгийг хуулийн байгууллага шалгаж тогтоосон".

Кейс 4: Гэрч А-ын өгсөн мэдүүлэг "...Миний бие 2015.11.29-ний өдөр болсон захирагчийн сонгуульд нэр дэвшиж, ...би сонгогчдын хамгийн олонх буюу 48.85%-ийн санал авсан. Захирагчийн сонгуульд өрсөлдсөн хэн ч 50-аас дээш хувийн санал авч чадаагүй учраас Ногооннуур сумын сонгуулийн хорооноос 12 дугаар сарын 03-ны өдөр дахин сонгууль явуулна гэж шийдвэрлэсэн... Гэвч захирагчийн сонгуульд надтай хамт өрсөлдсөн Е ах нь болох А нь 2015.12.03-ны өдөр болох тосгоны захирагчийн сонгуульд өрсөлдөж буй Е-д санал өгөөрэй гэж иргэдэд мөнгө өгсөн ба дээрх иргэд манайд ирж надад мэдэгдсэнээр миний бие цагдаагийн газар гомдол гаргаж шалгуулсан болно... А нь дүү Е-г тосгоны захирагчийн дахин сонгуульд ялуулахын тулд олон хүнд мөнгө төгрөг тараасан болохыг үүгээр нотолж байна. Иймд уг асуудлыг шударгаар шалгаж өгнө үү. Бид нарт мөнгө авсан болохоо хэлээгүй олон хүнд мөнгө тараасан гэж бодож байна. Тийм болохоор 2015.12.03-ны өдрийн сонгуулиар Е нь сонгуульд оролцсон 688 сонгогчийн 361 иргэдийн саналыг худалдаж авч ялалт байгуулсан гэж бодож байна".

Кейс 5: Хохирогч Н-ын шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлэг: "2018 оны Хатгал тосгоны захирагчийн ээлжит болсон. Тэр сонгуульд нийт 1389 сонгогч саналаа өгсөн, өөрөөр хэлбэл 1389 санал саналын хайрцагт орсон. Энийг 2 хуваахад 694,5 буюу 695 санал авсан бол энэ хүн 50 хувь буюу олонхын санал авах ёстой байсан. Энэ сонгуулиар 695 хүний санал Г ч аваагүй, би ч аваагүй. Гэтэл сонгуулийн хорооныхон нэр дэвшигч Г-г тухай үедээ захирагч байсан учраас тэр хүнд давуу байдал олгож ялсан болгосон. Ингэж сонгуулийн дүнг буруу гаргасан... Нэхэмжилж байгаа зүйл гэвэл хэрвээ журмаараа бол Б, нэгдсэн хороо зөв дүн гаргасан бол 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдөр явагдсан сонгууль 10 дугаар сарын арван хэднээр хэн нь ялаагүй юм байна гээд дахин сонгууль явагдах ёстой. Дахин сонгууль болж Хатгалын ард түмэн хэнийгээ сонгоно уу нэгийг нь сонгоод асуудал шийдэгдсэн байх ёстой байсан. Энэ дүн буруу гарснаас болоод би маш олон удаа шүүх хурал, цагдаагийн газарт мэдүүлэг өгөх, тагнуулын газарт мэдүүлэг өгөх гээд маш их зүйл болсон байгаа. Энэтэй холбоотой 1,037,280 төгрөгийн хохирол нэхэмжилж байна".

Хэдийгээр сонгуулийн эрхийн зөрчлийн хэрэг, маргааны хянан шийдвэрлэх хугацаа нь хэт удаан байгаа тухай практикт асуудал дэвшүүлдэг ч ЭХХША-с бусад төрлийн маргааныг шийдвэрлэх хугацааг сайжруулах тодорхой зохицуулалтууд хууль тогтоомжид орж байгааг дурдах нь зүйтэй.

2.5. Гэмт хэргийн шалтгаан нөхцөл

Сонгуулийн эрхийн эсрэг цөөн тооны гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байгаа ба эдгээр гэмт хэргийн үйлдэгдсэн нөхцөл байдал, энэ судалгааны хүрээнд хийсэн бичил асуумж, УТН-ын төлөөлөлтэй хийсэн уулзалтын үр дүнд үндэслэн энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг дараах байдлаар тодорхойлох боломжтой байна. Үүнд:

- **Сонгогчийн боловсрол, хариуцлага:** Иргэдийн зарим хэсэг нь том намууд хэн нь илүү амлаж чадаж байна, тэр нь барианд ордог уралдааны хэлбэртэй нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөх хандлагатай байна. Үүнээс шалтгаалж, иргэдийн олонх нь өөрийн сонгуулийн эрх зөрчигдсөн эсэхийг таних мэдрэмж, чадамжгүй байна. Аливаа хүний эрхийн зөрчил нэн тэргүүнд хохирогчийн мэдрэмжээр тодорхойлогддог бол эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учирснаас бусдаар хүний эрхийн зөрчил гэж харахгүй байна. Иргэд эрх зөрчигдсөн асуудлаар гомдол гаргах хүсэлгүй, гаргасан гомдлын араас тууштай явах сонирхолгүй байна.
- **УТН-ын бодлого, ёс зүй:** Нам гишүүд, дэмжигчдээ зөвхөн сонгуульд ялалт байгуулах тухай ухуулж, ялалт байгуулсан эсэхээс намд ямар байр суурьтай байх нь тодорхойлогдож байна. Түүнчлэн намын дүрэм журамд, гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоосноос бусад тохиолдолд намын гишүүнд дотоод хариуцлагын тухай асуудал яригдахгүй, шударга бусаар өрсөлдсөн нь ил болсон ч ялалт байгуулсан л бол үүнийг байх ёстой мэтээр хүлээн зөвшөөрч, анхаарал хандуулахгүй байна. Тухайлбал, Энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд нь бүгд МАН-ын гишүүн дэмжигч, МАН-ын сонгуульт албан тушаалтан байх нь зонхилох байв. Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэх сэдэл, санаа зорилго зөвхөн том намын гишүүн, дэмжигчдэд байдаг болохыг жижиг намын төлөөлөл болон бие даан нэр дэвшигчид хэлж байв. Жижиг намууд хэрэв сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн нь нэр дэвшигчийг хасах хүртэл сөрөг үр дагавартай байж, энэ нь том намд маш том олз болж, бие даагчид, жижиг намууд хууль зөрчихгүй байхад онцгойлон анхаарал хандуулдаг байна.

- **Сонгуулийн процесс, үе шат:** Одоогийн сонгуулийн процессын хугацаанд сонгуулийн сурталчилгааны “14 хоног” нь жижиг намууд, бие даан нэр дэвшигчид өөрийгөө таниулах, мөрийн хөтөлбөрөө сурталчлах болон сонгуультай холбоотой маргааныг хянан шийдвэрлэхэд хэт богино хугацаа байна. Үүнээс шалтгаалж мөрийн хөтөлбөр, бодлогоор өрсөлдөхөөс илүү байнгын бэлэг сэлт тараах, боломж амлах, худалдан авах зэргээр хялбар аргаар иргэдийн саналыг татахад анхаарал хандуулдаг байдал ажиглагдаж байна.
- **Сонгуулийн маргаан хянан шийдвэрлэхэд хамаарах хугацаа:** Сонгуулийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн хугацаа ердийн гэмт хэрэг шийдвэрлэх хугацаатай ижил байгаа нь гэмт хэргийг шалган шийдвэрлэх ач холбогдлыг бууруулж байна. Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх гол зорилго нь зөрчигдсөн эрхийг сэргээх явдал байх боловч нэгэнт сонгууль өнгөрч сонгуулийн үр дүнг зарласан бол маргаан шийдвэрлүүлэхийг гомдол гаргагч тал эрмэлзэхгүй байна.
- **Гэмт хэргийн илрүүлэх, нотлох ажиллагаа:** Өмнөх ижил төстэй сонгуулийн маргааны шийдвэрлэлт хангалтгүй байгаа нь дахин гэмт хэрэг үйлдэх гол шалтгаан болдог. Хуулийн хийдэл, давхардсан зохицуулалт зэрэг нь гэмт хэрэг илрэхгүй байх, нууц далд аргаар үйлдэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

ГУРАВ. СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙГ ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ

Сонгуулийн эрх нь ардчилсан улс орнуудад адил төстэй байх буюу НҮБ-ын гишүүн улс орнуудын хувьд хүний эрхийн баримт бичгүүдийг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг тул сонгуулийн эрхийн зөрчил нь хүний эрхийн зөрчил байж, зайлшгүй анхаарч, хэрэгжилтийг сайжруулахад ахиц дэвшил гаргаж байх шаардлагатай асуудал байдаг.

Манай СЕХ нь сонгуулийн тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн асуудлаар Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Орос Улс, Өмнөд Солонгос Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс зэрэг дөрвөн улстай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, сонгуулийн байгууллагуудын үйл ажиллагааны туршлага солилцох, ажилтан солилцоо, мэргэжилтэн бэлтгэх зэрэг үйл ажиллагаануудыг хийж байна.³⁸ Эдгээр 4 улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Орос Улс, Өмнөд Солонгос Улсын сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан байдлыг өөрийн орны холбогдох эрх зүйн зохицуулалттай харьцуулан үзлээ.

ХБНГУ, БНСУ, ОХУ-ууд нь сонгуулийн холимог тогтолцоотой ба ОХУ, БНСУ-ын хувьд холимог тогтолцооны параллель хувилбараар суудал хуваарилдаг³⁹ бол, ХБНГУ-ын тухайд холимог тогтолцооны холимог хувь тэнцүүлсэн хувилбараар суудал хуваарилдаг⁴⁰ байна.

³⁸ <https://www.gec.gov.mn/blog/2210>

³⁹ Б.Батцэнгэл, Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндсэн хуулийн орчуулга, УБ., 2021;

⁴⁰ Сонгуулийн холимог тогтолцоот улс орнуудын сонгогчдын санал гаргах хувилбарууд,

3.1. Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн харьцуулалт

Ихэнх улс орнуудад сонгуулийн холбогдолтой гэмт хэрэгт, эрүүгийн хэргийн шүүхээс хариуцлага оногдуулдаг бол зарим улс оронд сонгуулийн маргаан шийдвэрлэх дагнасан шүүхээр шийдвэрлэдэг тохиолдол байна. Энд харьцуулж буй ХБНГУ-ын тухайд, Парламентын сонгуулийн дүнг баталгаажуулах эрхийг шүүхийн болон хууль тогтоох байгууллагын аль аль нь хэрэгжүүлдэг ба сонгуультай холбоотой асуудлыг шийдвэрлэх хосолмол тогтолцоотой байгаа боловч Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүх нь эцсийн шийдвэр гаргаж байгаа учраас уг тогтолцоог шүүхийн систем давамгайлсан гэж үздэг. ОХУ-ын хувьд дөрвөн шатлал бүхий сонгуулийн удирдлагын байгууллагатай ба сонгуулийн маргааныг сонгуулийн хороод, шүүхийн байгууллага шийдвэрлэдэг байна. Харин Өмнөд Солонгос улсын тухайд, хууль тогтоох байгууллагын сонгуультай холбоотой маргааныг УДШ нь шийддэг ба Дээд шүүх нь сонгуулийн маргааныг анхан шатны журмаар шийдвэрлэдэг байна. Түүнчлэн сонгуулийн холбоотой зөрчил, маргааныг харьяалан шийдвэрлэхээс гадна мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах эрх хэмжээтэй Үндэсний сонгуулийн комисс ажилладаг.⁴¹ Эдгээр улсуудын Эрүүгийн хууль дах сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн зохицуулалтыг харьцуулж үзлээ.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд, сонгуулийн үйл ажиллагаанд саад учруулах, сонгогчид шахалт үзүүлэх гэсэн ерөнхий 2 хэсэгт хувааж, гэмт үйлдлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Сонгуулийн үйл ажиллагаанд саад учруулах гэмт хэрэгт:* Саад учруулах, сонгуулийн үйл ажиллагаанд хуурч мэхлэх үйлдэл гаргах, сонгуулийн баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал нууц байх зарчмыг зөрчих зэрэг үйлдлүүд;
- *Сонгогчид шахалт үзүүлэх гэмт хэрэгт:* Сонгогчид хүч хэрэглэсэн, хэрэглэхээр заналхийлсэн, сонгогчийг хууран мэхлэх, сонгогчид авлига өгөх, сонгогдсон этгээдэд авлига өгөх болон түүнээс авлига авах үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилжээ.

ХБНГУ-ын эрүүгийн хуулийн дээрх зохицуулалтын онцлог нь аль сонгуульд хамаарах хүрээ хязгаарыг зааснаас гадна, сонгуулийн үйл ажиллагаанд хуурч мэхлэх үйлдлийн завдалтыг гэмт хэрэгт тооцож ял оногдуулах, саналаа худалдсан үйлдэл буюу сонгогдсон этгээдээс авлига авсан үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна.

⁴¹ Д.Бат-Эрдэнэ, Парламентын сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх хэргийн харьяалал, УБ., 2022, 6-7 дахь тал;

ОХУ-ын Эрүүгийн хуульд, сонгуулийн эрхээ хэрэгжүүлэх болон сонгуулийн комиссын ажилд саад учруулах; сонгуулийн баримт бичиг, бүх нийтийн санал санал асуулга явуулах баримт бичиг хуурамчаар үйлдэх гэсэн 2 хэсэгт, гэмт үйлдлийг дараах байдлаар заажээ.

- Сонгуулийн эрхээ хэрэгжүүлэх болон сонгуулийн комиссын ажилд саад учруулах гэмт хэрэгт: Нэр дэвшигчийн компанит ажил, сонгуулийн хороо, бүх нийтийн санал асуулгад оролцогчдын бүлгийн сонгуулийн сурталчилгааг санхүүжүүлэх журам зөрчих;
- Сонгуулийн баримт бичиг, бүх нийтийн санал санал асуулга явуулах баримт бичиг хуурамчаар үйлдэх гэмт хэрэгт сонгуулийн үр дүнг хуурамчаар үйлдэх, бүх нийтийн санал асуулгын саналын хуудсыг хууль бус гаргах, хүлээн авах үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна.⁴²

БНСУ-ын Эрүүгийн хуульд⁴³, VII бүлэгт, Төрийн албан тушаалтан үүргээ холбоотой гэмт хэргүүдийн хэсэгт, төрийн албан үүргээ гүйцэтгэх явцдаа үйлдсэн гэмт хэргүүдийг хуульчилсны дотор, сонгуульд саад учруулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцдог ажээ.

3.2. Ялын бодлогын чиглэлээрх харьцуулалт

Улс орон бүр өөрийн орны үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашиг, хүний хувийн эрх эрх чөлөөг хамгаалах зорилгод чиглэсэн эрүүгийн ялын бодлого, зорилгоо тодорхойлж гэмт хэрэгт оногдуулах ялын төрлүүдийг зааж хуульчилсан байдаг. Тухайлбал, ОХУ-ын тухайд эрүүгийн хариуцлагын зорилгыг “Нийгэмд шударга ёсыг сэргээн тогтоох, ялтныг засан хүмүүжүүлэх болон дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх” хэмээн тодорхойлсон нь ял эдлүүлэх ажиллагааны гол агуулгыг гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн этгээдийг засан хүмүүжүүлэх буюу ялтныг тодорхой арга хэлбэрийг ашиглан хуулийг сахин биелүүлдэг, нийгмийн харилцаанд оролцохдоо бусдын эрх ашгийг дээдлэн хүндэтгэдэг зөв иргэн болгон төлөвшүүлэхэд чиглүүлжээ хэмээн үзэж болох юм. Харин манай улсын тухайд, “Иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх” гэсэн нь “зөрчигдсөн эрхийг сэргээх” тухай асуудлыг багтаасан байна. Өөрөөр хэлбэл

⁴² Ж.Эрдэнэбулган нар, Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль, УБ., 2021;

⁴³ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=28627&lang=ENG

хуулийн санаа нь гэмт хэрэгтэнд ял оногдуулснаар хохирогчийн зөрчигдсэн эрх сэргээгдэх мэт ойлголтыг бий болгож байна.

Сонгон авсан улс орнуудын хууль тогтоомжид тусгасан ялын төрлүүдийг доор авч үзлээ.

- **ОХУ:** Торгох; Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах; Төрийн шагнал, тусгай, хүндэт, цэргийн цол зэргийг хураах; Заавал гүйцэтгэх ажил хийлгэх; Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх; Цэргийн алба хаахыг хязгаарлах; Эрх чөлөөг хязгаарлах; Албадан ажил хийлгэх; Баривчлах; Цэргийн сахилгын хэсэгт хорих; Тодорхой хугацаагаар хорих; Бүх насаар хорих; Цаазаар авах;
- **ХБНГУ:** Торгох; хорих гэсэн үндсэн 2 ялын төрөлтэй. Эрх хасах нэмэлтээр оногдуулж болдог.
- **БНСУ:** Цаазаар авах ял, хүнд хөдөлмөр хийлгэхгүйгээр хорих, хорих, эрх хас, эрх түдгэлзүүлэх, нийтэд тустай ажил хийлгэх, торгох, баривчлах, эд хөрөнгө хураах зэрэг ялын төрөлтэй.

Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт оногдуулж ялын байдлыг харьцуулан хүснэгтэд үзүүлээ.

ХҮСНЭГТ 18. ЗАРИМ УЛС ОРНУУДЫН СОНГУУЛИЙН ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТ ОНОГДУУЛАХ ЯЛЫН ТӨРӨЛ

| № | | ХБНГУ | ОХУ | БНСУ | Монгол Улс |
|---|---------------------|---|---|----------------|----------------------------|
| 1 | Эрүүгийн ялын төрөл | Торгох | Торгох | | Торгох |
| 2 | | | Албадан хөдөлмөр, Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх | | Нийтэд тустай ажил хийлгэх |
| 3 | | | | | Зорчих эрхийг хязгаарлах |
| 4 | | Хорих | Хорих | Хорих | Хорих |
| 5 | | Эрх хасах (Төрийн алба хаших, Олон нийтийн сонгуульд оролцох, Төрийн байгууллагын санал өгөх) | Төрийн алба хаших болон үйл ажиллагаа явуулах эрх хасах | Эрх хасах | Эрх хасах /нэмэгдэл/ |
| 6 | | | Баривчлах | | |
| 7 | | | | Хөрөнгө хураах | |

Дээрх 3 улсын ЭХ-д, сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэгт зонхилон хорих болон торгох ял шийтгэл оногдуулж мөн нэмэлтээр төрийн албан тушаал хаших, сонгуульд оролцох эрхийг хасах нэмэгдэл ялыг оногдуулах зохицуулалттай байна. Мөн гэмт хэрэгт тооцож болох сонгуулийн эрх зөрчсөн үйлдлийг нарийн тодорхой зааснаас гадна завдалтыг гэмт хэрэгт тооцох нөхцөлүүдийг хуульчилсан нь хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх, ялын үр нөлөөг сайжруулах давуу талтай байна.

ХҮСНЭГТ 19. СОНГУУЛИЙН ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД СААД УЧРУУЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ОНОГДУУЛАХ ХОРИХ БОЛОН ЯЛЫН ХЭМЖЭЭ

| Ялын төрөл | ХБНГУ | ОХУ | БНСУ | Монгол Улс |
|------------|--------------|--------------|----------------|----------------|
| Хорих | 5 жил хүртэл | 5 жил хүртэл | 10-аас доошгүй | 1-5 жил хүртэл |

Манай улсын сонгуулийн байгууллага, зүй ёсны сонгуулийн төлөө бусад улс оронтой хэрэгжүүлж буй хамтын ажиллагаа, харилцан туршлага нэвтрүүлж буй үйл ажиллагааны сайн үр нөлөөг үгүйсгэхгүй. Гэвч хамтын ажиллагааны хүрээнд дээрх улс орнуудаас зөвхөн сонгуулийн менежментийн асуудлаас гадна сонгуулийн эрхийн зөрчлийг хэрхэн хуульчилж, зөрчигдсэн эрхийг сэргээхэд анхаарч буй эрүүгийн процессын асуудлаар мөн туршлага солилцох хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх шаардлагатай байгааг дурдах нь зүйтэй байна.

ДУГНЭЛТ, САНАЛ

Манай улсын иргэдийн нийгэм-улс төрийн идэвх, оролцоо өсөж сонгууль, түүний хууль ёсны байдал, шударга үр дүнг шаардах хандлага нэмэгджээ. Шударга сонгуулийн үр дүн нь сонгуулийн процессын аль ч шатан дах иргэний зөрчигдсөн сонгуулийн эрхийг сэргээх асуудалтай шууд хамааралтай бөгөөд зөрчигдсөн эрхийг бодитоор болон тэгш байдалд нь сэргээн тогтоосон нь иргэний сонгуулийн үр дүнд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

Анх 2002 оны ЭХ-д сонгуулийн эрх зөрчсөн тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох зохицуулалт орсноос хойш даруй 20 жил өнгөрчээ. Энэ хугацаанд 30 орчим сонгууль зохион байгуулагдаж, иргэд “сонгуулийн үр дүн”-г сонгуулийн үеэр байнга гардаг зөрчил, маргаантай холбон тайлбарлах, хүлээн зөвшөөрөхгүй байх хэмжээнд хүртлээ мэддэг болжээ.

Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгосон ч энэ төрлийн гэмт хэргийн бүртгэл, шийдвэрлэсэн тоо баримт, нэгдсэн статистик байхгүй байна. МУ-ын шүүхийн шийдвэрийн цахим санд шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо ердөө 10 байна. Шийдвэрлэсэн хэргийн тоо их биш байгаа ч эсрэгээрээ сонгуулийн жилүүдэд сонгуультай холбоотой цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гомдол, мэдээллийн тоо харьцангуй өндөр байгаа нь анхаарал татаж байв. Тухайлбал, шинэ ЭХ, Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийн жилд цагдаагийн байгууллагын шалган шийдвэрлэсэн 181 зөрчил, гэмт хэрэг 4 байгаа бол шүүхээр шийдвэрлэсэн нэг ч хэрэг байхгүй байна. Иймд, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхгүй байна гэж дүгнэх боломжгүй юм. Гэмт хэрэг шийдвэрлэлт цөөн байгаа нь хэрэг үйлдсэн этгээд хариуцлагаас мултрах, дахин гэмт хэрэг үйлдэх, зөрчигдсөн сонгуулийн эрх сэргээгдэхгүй байх шалтгаан болно. Тодруулбал, судалгааны хүрээнд шат шатны сонгуулийн нэр дэвшигчдээс авсан бичил асуумжийн үр дүн болон шүүхийн шийдвэрээс гарсан хохирогчийн эрх сэргээх асуудлыг шинжилж үзэхэд нэгэнт сонгох, сонгогдох эрх нь зөрчигдсөн бол сэргээгдэх боломжгүй нөхцөл үүссэн байна.

2015 оны шинэчлэн найруулагдсан ЭХ-ийн өөрчлөлтөөс сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийг оновчтой зүйлчлэх, зөрчлийн хэргээс ялган таних, ялын бодлогыг тохиромжтой болгох зэрэг зарим асуудлуудыг хөндөх шаардлагатай байна. Тухайлбал,

- Сонгогчийн саналыг татах зорилгоор эд хөрөнгө, мөнгө тараасан зөрчлийг ЭХ эсхүл Зөрчлийн хуулиар шийдвэрлэх боломжтой. Шинэ ЭХ-д “сонгогчийг эд хөрөнгө, мөнгөөр татаж санал худалдан авч үйлдсэн” гэсэн нөхцөл нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын нэмэлт шинж, цаг үе нөхцөл байдлыг тодруулах буюу иргэн сонгуулиа өгсөн байх шаардлага үүсгэжээ. 2012-2017 оны хооронд “хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх, эд мөнгөөр татах, санал худалдаж авах зэрэг аргаар үйлдсэн” гэсэн зохицуулалтаар нийт 5 гэмт хэргийг 2002 оны ЭХ-иар шийдвэрлэсэн бол, шинэ ЭХ-ийн зохицуулалтаар шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг байхгүй байна.
- ЭХ-ийн 14.9 дүгээр зүйлд сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх зорилгоор тус хуулийн 14.5, 14.6, 14.7 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдэхэд бэлтгэсэн, зохион байгуулсан бол хэрхэн шийдвэрлэхийг тусад нь зүйлчилж өгчээ. Гэтэл дурдсан гэмт хэргүүд нь сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх санаа зорилгыг агуулж байдаг тул бэлтгэх, зохион байгуулах үйлдлийг өөр гэмт хэрэг болгон зүйлчилсэн нь ойлгомжгүй байна. Хэрэв тухайн гэмт хэргийг зохион байгуулалттай үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүн эсвэл ял оногдуулахад харгалзах, бэлтгэсэн үйлдлийг ЭХ-ийн 2.7-оор зохицуулах боломжтой;
- Оногдуулах ялын сонголт нь эрүүгийн хариуцлагын цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ялын бодлогод нийцээгүй байна;
- Өмнөх хуулийн “сонгуулийг будилаантуулж төрийн эрх мэдлийг авах” гэмт хэргийг хасаж, ЭХТА-ийн 19.2. Төрийн эрхийн мэдлийг хууль бусаар авах, саатуулах гэсэн зүйл ангид “...хүчирхийллийн аргаар авахад бэлтгэсэн...” гэж өөрчилсөн нь сонгуулийн аргаар төрийн эрх мэдлийг авах гэсэн үйлдлийг дангаар, болон давхар зүйлчлэх боломжгүй болгожээ.

ЭХ-ийн хэрэглээний талаар харьцуулалт, дүн шинжилгээ хийх, холбогдох зохицуулалтыг өөрчлөх эсхүл сайжруулах талаар асуудал дэвшүүлэхэд ач холбогдол бүхий шүүхийн шийдвэр хомс байна. Харин сонгуулийн хууль тогтоомжид ойр ойрхон өөрчлөлт орж байгаа нь гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэхэд хүндрэл учруулж байсан ч, хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх

талаар тухай бүрд нь ямар нэг тайлбар гаргаагүй байна. Үүнээс шалтгаалж, санал татах зорилгоор мөнгө тараасан гэмт хэргийг зөрчлөөс ялган зүйлчлэхэд хуулийг буруу тайлбарлаж, төсөөтэй хэргийг өөр өөрөөр шийдвэрлэжээ. Иймд хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд УДШ-ийн албан тайлбар шаардлагатай гэж үзэж байна.

Хэрэг хянан шийдвэрлэж буй практикт, хэрэг шийдвэрлэлтийн дундаж хугацаа нэг жил байгаа нь нэгэнт сонгуулийн үр дүн тодорхой болсон тохиолдолд өргөдөл, гомдол гаргагчийн идэвх, оролцоо буурах, зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй, хэргийг шүүхээр шийдвэрлэх ач холбогдлыг бууруулж байна. Нотлох баримтыг хэрхэн үнэлж байгаа тодорхой тайлбарыг шүүхийн шийдвэрт тусгасан нь хангалтгүй, хэрэгт ач холбогдол бүхий зарим баримтыг шийдвэр гаргахад харгалзан үзээгүй байв. Тухайлбал, гэмт хэрэгт хамтран оролцсон, тээврийн хэрэгсэл ашигласан байдлыг харгалзаагүй, зөвхөн шүүгдэгчдийн мэдүүлэгт үндэслэн цагаатгасан зэргээр өнгөц ханджээ. Түүнчлэн шүүхээс зөвхөн гэм буруутай этгээдэд ял оногдуулахад анхаардаг нийтлэг практик энэ гэмт хэргийн шийдвэрлэлтэд мөн адил дүр зурагтай байгаа ч дийлэнх хэрэгт торгох ял оногдуулж байгаа нь гэм буруутай этгээдэд цээрлэл болж чадахгүй “ял оноосон” нэр төдий байна.

Хэдийгээр сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож байгаа ч зөрчигдсөн эрх сэргээгдэхгүй байгаа гол шалтгаан нь салбар хоорондын харилцан уялдаагүй зохицуулалттай холбоотой байна. 2015 оны Сонгуулийн тухай хуулийн “Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн нь маргаан хянан шийдвэрлэх эрх бүхий этгээдийн шийдвэрээр тогтоогдсон хэмжээгээр ... сонгуулийн дүн гаргасан шийдвэр хүчингүй болно” гэсэн зохицуулалт нь сонгуулийн зөрчигдсөн эрхийг сэргээх үндэслэл болж байжээ. Харамсалтай нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй сонгуулийн хуулиудад энэ зохицуулалт байхгүй бөгөөд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон ч санал хураалт, болон сонгуулийг хүчингүйд тооцох боломжгүй байна.

Хүний эрхийг хамгаалахын тулд сайтар боловсруулагдсан, салбар хоорондын аливаа зөрчилдөөнгүй хэм хэмжээний тогтолцоог бүрдүүлэх ёстой. Энэ утгаараа сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн зохицуулалтыг боловсронгуй болгох, зөрчилдөөнийг арилгах, бусад ардчилсан улс орны жишиг хандлагад нийцүүлэн гэмт хэрэгтний хувийн байдалд тохируулах байдлаар ялын бодлогыг өөрчлөх, хохирогчийн эрх сэргээх асуудлыг авч үзэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Энэ нь хүний эрхийг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мөн ял

завшуулахгүй байх эрүүгийн эрх зүйн үндсэн зорилгыг хангах нэг гол нөхцөл болох юм.

Монгол Улс сонгуулийг амжилттай зохион байгуулж, төрийн эрх мэдлийг сонгуулийн үр дүнгийн дагуу тайван замаар шилжүүлэх соёл төлөвшсөн⁴⁴ гэж үзэж байгаа ч сонгуулийн үеэр иргэний сонгуулийн зөрчигдсөн эрх сэргээгдэх боломжгүй байгааг холбогдох бүх талууд онцгойлон анхаарч үзэх шаардлагатай байгааг дурдах нь зүйтэй юм.

Санал, зөвлөмж

- Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх нэгдсэн болон тухайлсан бодлого боловсруулж, хэрэгжүүлэх замаар хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдох талуудын үүрэг, оролцоог сайжруулах;
- Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дотоод болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх; Үүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд УТН-уудад мэдлэг, мэдээлэл олгох чиглэлд хамтын ажиллагаатай бусад улс орны туршлага судлах,
- Аливаа сонгуулийн дараа холбогдох байгууллагуудаас гаргасан гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг өөрийн цахим хуудсаар дамжуулан танилцуулж, сонгуулийн үр дүнгийн хүчин төгөлдөр байдлын баталгааг нэмэгдүүлэх;
- Монгол Улс дах гэмт хэргийн нөхцөл байдлын он, оны статистикт “Улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг” ангиллыг оруулж, сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн статистик, мэдээг бэлтгэн танилцуулах; Ялангуяа сонгуулийн жилүүдэд тусгайлан, энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал, цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гомдол, мэдээлэл, шүүхээр шийдвэрлэсэн хэрэг, зөрчлийн тоог дэлгэрэнгүй танилцуулдаг болох;
- ЭХХША-ны оролцогчдын энэ төрлийн гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд шаардлагатай ойлголт, мэдлэг, практик ур чадварыг дээшлүүлэх сургалт явуулах;
- Сонгуулийн кампанит ажил буюу сурталчилгааны хугацаа нь улс орнуудад

⁴⁴ О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл, Тойм судалгаа, УБ., 2021 он, , 162 дахь тал;

өөр өөр байх бөгөөд ихдээ 150 хоног, хугацаагүй байдлаар ч тогтоосон⁴⁵ байдаг. Үүнийг тухайн улс өөрийн онцлогт тохируулан тодорхойлдог бөгөөд манай улсын хувьд газар нутгийн хэмжээ, иргэний сонгуулийн боловсрол, УТН-уудын нөхцөл байдал, ардчиллын хөгжил зэргийг шалгуур болгон сонгуулийн сурталчилгааны хугацааг уртасгах;

- Сонгуулийн холбогдолтой өргөдөл, гомдлыг шалган шийдвэрлэхэд хойшлуулшгүй ажиллагааг түргэн шуурхай явуулах, сонгуулийн зохион байгуулалтын хугацаатай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг уялдуулан тооцож, тогтоох;
- Сонгуулийн эрхийн эрүүгийн эрх зүйн хамгаалалт, иргэний сонгох, сонгогдох эрхийг бүхэлд нь хамгаалах хүрээнд ЭХ-ийн 14.5 “Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх”, 14.9 “Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах” гэмт хэргийн бүрэлдэхүүнүүдийг тус бүр задлан шинжилж, давхардал үүсгэсэн, орхигдуулсан асуудлыг тогтоож, шинэчлэх;
- ЭХ, Зөрчлийн тухай хуульд заасан “Сонгогчийн санал татах зорилгоор эд зүйл, мөнгө тараасан” үйлдлийн зөрчилдөөнтэй хэм хэмжээний аль нэгийг хүчингүй болгох, эсвэл аль нэгийг өөрчлөх замаар нийцүүлэх;
- Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн онцлог байдлыг харгалзан ялын тохиромжтой байдалд тодорхой шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх; Ингэхдээ ял эзнээ олсон, гэмт хэрэгтэнд нөлөө үзүүлэхүйц байхаар оногдуулдаг болох зарчимд нийцүүлж зарим зүйл ангиас торгох, зорчих эрх хязгаарлах ялыг хасах, өөрчлөх; эрх хасах, эд хөрөнгө хураах зэрэг нэмэгдэл ялыг сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд заавал оногдуулдаг болох;
- Зөрчигдсэн эрхийг сэргээх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахад салбар хоорондын уялдаа холбоотой эрх зүйн зохицуулалтыг бий болгох, өөрөөр хэлбэл сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдсон нь сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлсөн нөхцөлийг тогтоож болохыг харгалзан сонгуулийн үр дүнд бүхэлд нь болон зарим хамаарах хэсгээр хүчингүйд тооцох зохицуулалтыг сонгуулийн холбогдох хуулиудад оруулах.

⁴⁵ https://aceproject.org/ace-en/topics/me/mea/mec02/mobile_browsing/onePag

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Эрх зүйн баримт бичиг:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль
- Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
- Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Эрүүгийн хууль 2002, 2015
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт
- Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах конвенц

Ном, гарын авлага, илтгэл:

- Д.Бат-Эрдэнэ, Парламентын сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх хэргийн харьяалал, УБ., 2022
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй, УБ., 2011
- С.Нарангэрэл, Гэмт хэргийн зүйлчлэлийн шинжлэх ухааны үндэс, УБ., 1988
- Б.Ганболд "Гэмт хэрэг зүйлчлэлийн онол", УБ., 2001
- Г.Эрдэнэбат, "Эрүүгийн эрх зүй", УБ., 2007
- Б.Ганболд, Өршөөлийн эрх зүй, УБ., 2015
- С.Гантулга, Б.Энхболд "Эрүүгийн эрх зүй: Тусгай анги" сурах бичиг, УБ., 2021

- В.Эрдэнэбаяр, Д.Мягмарцэрэн, Г.Бямбадорж Я.Цэлмэн, Д.Сумъяацэрэн, Э.Золбоо, Монгол Улсад сонгууль зохион явуулахтай холбоотой гардаг гэмт хэрэг, зөрчлийг шалгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гарын авлага, УБ., 2016
- Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь, судалгааны тайлан, УБ., 2014
- Ж.Эрдэнэбулган нар, Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль, УБ., 2021
- О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дах Хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл” Тойм судалгаа, УБ., 2021

Гадаад эх сурвалж:

- ХБНГУ-ын Эрүүгийн хууль
https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html
- ОХУ-ын Эрүүгийн хууль
<https://www.documentcloud.org/documents/24106785-russian-federation-criminal-code>
- БНСУ-ын Эрүүгийн хууль https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=28627&lang=ENG

Улс төрийн намын дүрэм:

- МАН-ын дүрэм
- АН-ын дүрэм
- ХҮН намын дүрэм

Ярилцлага:

- Улс төрийн намын гишүүнтэй хийсэн ярилцлага (ХҮН нам)

ХАВСРАЛТ - 1

Сонгуулийн болон бүх нийтийн санал асуулгатай холбогдолтой гэмт хэргийн зарим нэр томьёог хууль зүйн талаас нь дараах байдлаар ойлгож хэрэглэнэ.

Иргэн сонгох, сонгогдох, бүх нийтийн санал асуулгад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах гэдэгт, МУ-ын Үндсэн хууль болон холбогдох хуульд тусгайлан заасан хориг, хязгаарлалтаас бусад тохиолдолд иргэний дээрх эрхийг аливаа хэлбэрээр эдлүүлэхгүй байгаа санаатай үйлдэл (эс үйлдэхүй) байна. Жишээлбэл, УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 5.4-р зүйлд Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй гэсэн зохицуулалт нь иргэний сонгох эрхэд хийсэн хязгаарлалт бөгөөд хуульд зааснаас өөрөөр сонгуулийн эрхээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарласныг ойлгоно.

Сонгуулийн хорооны ажилд саад хийх гэдэгт, хууль тогтоомжоор сонгууль болон ард нийтийн санал асуулгыг эрхлэн явуулах эрх бүхий сонгуулийн төв, орон нутгийн байгууллага болон түүний хэрэгжүүлэх үйл ажиллагааг заасан. Энэ байгууллагуудын зохих ёсны үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байдалд хүргэсэн эсхүл хүндрэл учруулсан аливаа санаатай үйлдэл (эс үйлдэхүй) байна. Жишээлбэл, сонгууль зохион байгуулахаар төлөвлөсөн санал авах байрыг суллаж өгөхөөс татгалзах, төлбөр шаардах гэх мэт.

Хүч хэрэглэж гэдэгт, иргэний сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан цохиж зодох, бие эрхтэнд нь гэмтэл учруулах, хууль бусаар баривчлах, саатуулах зэрэг үйлдлээр дамжуулан эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдалд хүргэснийг ойлгоно.

Хүч хэрэглэхээр заналхийлж гэдэгт, элдэв хэлбэрээр сэтгэл санааны тавгүй байдалд оруулах, “зодно, ойр дотнын хүмүүсийн амь биед халдана, эд хөрөнгө устгана, нэр төр гутаана, нууц задруулна” гэж айлган сүрдүүлж дарамтлахыг хэлнэ.

Хууран мэхэлж гэдэгт, үгээр болон үйлдлээр бодит байдлыг гуйвуулах, нуун дарагдуулах эсвэл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар төөрөгдүүлэхийг хэлнэ.

Сонгогчийг эд хөрөнгө, мөнгөөр татаж санал худалдаж авч үйлдсэн гэдэгт, иргэнийг сонгуульд оролцохоос татгалзуулах эсвэл нэр дэвшигчид санал өгүүлэхийн тулд мөнгө, эд хөрөнгө өгсөн, эд хөрөнгийн давуу байдал эрх олгосон, ажил үйлчилгээг төлбөргүй үзүүлсэн зэргээр сонгогчийг чөлөөтэй сонголт хийх боломжгүй байдалд оруулж, нөлөөлснийг ойлгоно.

Сонгуульд нэгээс илүү удаа санал өгсөн, нэгээс илүү удаа санал өгөхийг зохион байгуулсан гэдэгт, сонгуулийн хууль тогтоомжид зааснаар аливаа сонгуульд сонгогч бүр саналын нэг эрхтэй. Үүнийг зөрчиж, сонгогч өөрөө дахин санал өгсөн, эсвэл бусдаар санал өгүүлэхээр зохион байгуулсныг ойлгоно.

Улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулсан гэдэгт, сонгуулийн зохион байгуулалтад хуулиар чиг үүрэг гүйцэтгэж оролцож байгаа этгээд нь “Сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигч болон түүний менежер, шадар туслагч ухуулагчаас бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно” гэснийг зөрчсөн, үүрэгт багтаагүй үйл ажиллагаа явуулж нэг талын эрх ашигт үйлчилснээр илэрнэ.

Санал хураалтын дүнг өөрчилсөн гэдэгт, Санал авах ажиллагаа дуусмагц санал авах байрууд тоног төхөөрөмжийг унтрааж, гарсан дүнгийн хуудас, санал хураалтын үр дүнгийн мэдээллийг СЕХ руу тэр даруй дамжуулдаг. Гэвч, төхөөрөмжөөр санал хураалтын үр дүнг тоолох явцад гаднаас нөлөөлж үр дүнг өөрчилсөн болон төхөөрөмжөөр нэгэнт тоолж дууссаны дараа тэмдэглэл үйлдэх, баталгаажуулах зэрэг явцад зориудаар үр дүнг өөрчилсөн буюу тоог нэмсэн, хассан байх зэргийг ойлгоно.

Сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх зорилгоор сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэхэд бэлтгэсэн, зохион байгуулсан гэдэгт, хоёр ба түүнээс дээш этгээд нэгдэн, сонгуулийг хууль бусаар явуулах зорилгын дор нэгдсэн, төлөвлөгөө боловсруулсан, арга замаа тодорхойлсон, гишүүддээ үүрэг хуваарилсан нууц далд ажиллагаа явуулахыг хэлнэ.

Зохион байгуулсан гэдэгт, гэмт хэрэг үйлдэхээр санаачилсан, удирдсан, төлөвлөсөн, гэмт хэрэг хамтран үйлдэгчдийн үүрэг, оролцоог хуваарилсан, энэ чиглэлээр ажиллах зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан байхыг ойлгоно.

ХАВСРАЛТ – 2

Сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийг Зарим улс орны Эрүүгийн хууль тогтоомжид тусгасан байдал

I. ХБНГУ-ын ЭХ-ийн дах зохицуулалт

107. Сонгуулийн үйл ажиллагаанд саад учруулах

1. Сонгуулийн үйл ажиллагаа явуулах буюу сонгуулийн дүнг зарлах үед хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж түүнд саад учруулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял, онц ноцтой тохиолдолд нэгээс доошгүй жилийн хорих ял шийтгэнэ.
2. Уг гэмт хэргийн завдалтад ял оногдуулна.

107a Сонгуулийн үйл ажиллагаатай холбогдуулан хуурч мэхлэх

1. Зөвшөөрөлгүйгээр санал өгсөн, сонгуулийн үр дүнг буруу гаргасан эсвэл сонгуулийн үр дүнг хуурамчаар үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял эсвэл торгох ял шийтгэнэ.
2. Сонгуулийн үр дүнг буруу зарласан эсвэл зарлуулсан бол мөн адил ял шийтгэнэ.
3. Уг гэмт хэргийн завдалтад ял оногдуулна.

107b Сонгуулийн баримт бичгийг хуурамчаар үйлдэх

1. Гэмт хэрэгтэн
 - 1) Хуурамч мэдээлэл өгөх аргаар сонгогчдын нэрсийн жагсаалтад / сонгуулийн бүртгэл/ бүртгүүлсэн.
 - 2) Нэрсийн жагсаалтад орох эрхгүй гэдгийг мэдсэн хэр нь бусад этгээдийг сонгогчоор бүртгэсэн,
 - 3) Сонгуульд оролцох эрхтэй гэдгийг мэдсэн хэр нь сонгуульд оролцох эрх бүхий этгээдийг сонгогчоор бүртгэхэд саад учруулсан,

- 4) Сонгуульд нэр дэвших эрхгүй хэр нь сонгуульд нэр дэвшсэн бол энэ хуулийн бусад зүйлд зааснаар хохирол учруулаагүй тохиолдолд зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял эсвэл зуун ная хүртэл өдрийн ханшаар торгох ял шийтгэнэ.
2. Сонгогчдын нэрсийн жагсаалтад сонгогчийг бүртгэх бүртгэл нийгмийн даатгалын анхан шатны сонгуульд зориулж гаргасан сонгуулийн баримт бичигт хамаарна.

107 с Санал нууц байх зарчмыг зөрчих

Бусдыг хэнд санал өгснийг мэдэх буюу өөр хэн нэгэнд мэдэгдэх зорилгоор саналын нууц байдлыг хамгаалахтай холбоотой журмыг зөрчсөн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял эсвэл торгох ял шийтгэнэ.

108 Сонгогчид шахалт үзүүлэх

1. Мэргэжил болог санхүүгийн хараат байдлыг ашиглан, эсвэл санхүүгийн дарамт үзүүлэх замаар бусдыг хэн нэгний төлөө санал өгөх буюу тодорхой байдлаар сонгох эрхээ хэрэгжүүлэхийг хүч хэрэглэж, ноцтой хохирол учруулахаар заналхийлж шахалт үзүүлсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял эсвэл торгох ял, онц ноцтой тохиолдлын хувьд нэгээс арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Уг гэмт хэргийн завдалтад ял оногдуулна.

108 а Сонгогчийг хууран мэхлэх

1. Хууран мэхлэх замаар сонгогчийн хүсэл зоригийн эсрэг санал өгүүлсэн, хүчингүй санал өгсөн эсвэл санал өгүүлээгүй бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял эсвэл торгох ял шийтгэнэ.
2. Уг гэмт хэргийн завдалтад ял оногдуулна.

108 б Сонгогчид авлига өгөх

1. Бусдад бэлэг эсвэл давуу тал санал болгож, амлаж эсвэл баталгаа өгөх замаар санал өгүүлсэн эсхүл өгүүлээгүй бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял эсвэл торгох ял шийтгэнэ.
2. Бусад этгээд ийнхүү бэлэг эсвэл давуу тал амлахыг дэмжсэн, амлахад хүргэсэн эсвэл бэлэг, давуу байдлыг хүлээн авсан бол мөн адил ял шийтгэнэ.

108 с Нэмэлт үр дагавар

Энэ хуулийн 107, 107а, 108 болон 108b дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэний улмаас зургаан сараас доошгүй хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн бол шүүх хорих ял дээр нэмэлт байдлаар төрийн алба хаших эрх, олон нийтийн сонгуульд оролцох эрх болон төрийн байгууллагын сонгууль өгөх буюу санал өгөх зэрэг эрхүүдийг хасаж болно.

108 d Үйлчлэх хүрээ хязгаар

Энэ хуулийн 107-108с дугаар зүйл нь төлөөллийн байгууллагын сонгууль, Европын парламентын сонгууль болон Холбооны улсын ард иргэдийн оролцдог бусад төрлийн сонгууль болон санал хураалтад хамаарна. Харин муж болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын хувьд мужийн нутаг дэвсгэрийн эсвэл орон нутгийн засаг захиргааны байгууллагын аль нэг хэсэгт зохион байгуулагдаж буй сонгууль болон санал хураалт эсвэл нийгмийн даатгалын анхан шатны сонгууль зэрэгт хамаарна. Сонгуулийн саналд гарын үсэг зурах эсвэл бүх нийтийн санал асуулгад гарын үсэг зурахыг сонгууль эсвэл санал хураалт өгсөн гэж үзнэ.

108e Сонгогдсон этгээдэд авлига өгөх болон түүнээс авлига авах

1. Холбооны улсын болон мужийн парламентын гишүүний хувиар өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцдаа түүнд хүсэлт тавьсан эсвэл зааварчилгаа өгсний дагуу ямар нэгэн үйлдэл хийсэн, хийхээс татгалзсанахаа төлөө үндэслэлгүйгээр өөртөө давуу тал үүсгэх эсвэл гуравдагч этгээдэд давуу тал үүсгэхээр амлах, дэмжлэг үзүүлэх эсвэл үүнийг хүлээн зөвшөөрүүлсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял эсвэл торгох ял шийтгэнэ.
2. Холбооны улсын болон мужийн парламентын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцдаа түүнд хүсэлт тавьсан эсвэл зааварчилгаа өгсний дагуу ямар нэгэн үйлдэл хийсэн, хийхээс татгалзсанахаа төлөө үндэслэлгүйгээр өөртөө давуу байдал үүсгэх эсвэл гуравдагч этгээдэд давуу байдал үүсгэхээр амлалт авах, дэмжлэг авах, эсвэл үүнийг хүлээн зөвшөөрсөн бол мөн адил ял шийтгэнэ.
3. Энэ зүйлийн 1 болон 2 дах хэсэгт заасан гишүүн гэдэгт дараах байгууллагын гишүүд хамаарна.
 - Орон нутгийн засаг захиргааны байгууллагын иргэдийн төлөөлөгч,
 - Муж эсвэл орон нутгийн засаг захиргааны байгууллагыг бүрдүүлж буй захиргааны нэгжийн хувьд шууд, бүх нийтээрээ сонгосон зөвлөл

- Холбооны улсын хурал
 - Европын парламент
 - Олон улсын байгууллагын парламентын хурал
 - Гадаад улсын хууль тогтоох байгууллага
4. Тухайн гишүүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу давуу тал олж авах тухай заасан тохиолдолд үүнийг үндэслэлгүй давуу тал гэж үзэхгүй. Дараах тохиолдолд үндэслэлгүйгээр давуу тал олж авсан гэж үзэхгүй.
- Улс төрийн бүрэн эрх эсвэл улс төрийн чиг үүрэг
 - Улс төрийн намын тухай хууль эсвэл бусад холбогдох хуулийн дагуу олж авсан хандив
 - Зургаан сараас доошгүй хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн бол шүүх хорих ял дээр нэмэлт байдлаар төрийн алба хаших эрх, олон нийтийн сонгуульд оролцох эрх болон төрийн байгууллагын сонгууль өгөх буюу санал өгөх буюу санал өгөх зэрэг эрхүүдийг хасаж болно.

II. Оросын Холбооны Улсын Эрүүгийн хууль тогтоомж дах зохицуулалт

141 дүгээр зүйл. Сонгуулийн эрхээ хэрэгжүүлэх болон сонгуулийн комиссын ажилд саад учруулах

1. Иргэнээс сонгуулийн эрх буюу ард нийтийн санал асуулгад оролцох эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэхэд саад учруулсан, саналын нууцыг зөрчсөн, түүнчлэн сонгуулийн хорооны ажил, эсхүл өөрийн үүргээ гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан сонгуулийн хорооны гишүүний үйл ажиллагаанд саад хийсэн бол наян мянга хүртэл рубль эсхүл ялтны зургаан сар хүртэлх хугацааны цалин хөлс бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл гурван зуун жаран цаг хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.
2. Энэ хэргийг
 - а) Худалдан авах, хуурч мэхлэх, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар
 - б) Албан тушаалын байдлаа ашиглаж
 - с) Урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол нэг зуун мянгаас гурван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр

торгох эсхүл дөрвөн зуун наян цаг албадан хөдөлмөр хийлгэх эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Сонгуулийн хороо, ард нийтийн санал асуулга зохион байгуулах комисс сонгуулийн болон санал асуулга явуулах тухай хууль тогтоомжоор тогтоосон бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад нь албан тушаалын байдлаа ашиглаж, түүний шийдвэрт нөлөөлөх зорилгоор хөндлөнгөөс оролцох, үүнтэй холбоотойгоор албан тушаалтны нэр дэвшигчийг бүртгэх, санал тоолох, бүх нийтийн санал асуулгад оролцогчид болон сонгуулийн комисс, ард нийтийн санал асуулга явуулах комиссын бүрэн эрхэд хамаарах бусад асуудалд оролцох, түүнчлэн ОХУ-ын “Сонгууль” Төрийн автоматжуулсан системийн үйл ажиллагаанд хууль бусаар оролцсон бол хоёр зуугаас хоёр зуугаас таван мянга хүртэл рубль эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацааны хөдөлмөр хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл наян мянга хүртэл рубль эсхүл ялтны зургаан сар хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгож дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

141.1 дүгээр зүйл. Нэр дэвшигчийн компани т ажил, сонгуулийн хороо, бүх нийтийн санал асуулгад оролцогчдын бүлгийн сонгуулийн сурталчилгааг санхүүжүүлэх журам зөрчих

1. Сонгуулийн тодорхой үр дүнд хүрэх зорилгоор сонгуулийн зардлын дансанд оруулахгүйгээр их хэмжээтэй мөнгөн хөрөнгийг нэр дэвшигчид шилжүүлсэн, эсхүл сонгуулийн зардлын дансанд байгаагүй их хэмжээний мөнгөн хөрөнгийг зарцуулсан, эсхүл сонгуулийн тодорхой үр дүнд хүрэх зорилгоор нэр дэвшигч сонгуулийн зардлын данснаас гаргалгүйгээр их хэмжээтэй материаллаг үнэт зүйлсийг бусдад шилжүүлсэн буюу сонгуулийн тодорхой үр дүнд хүрэхэд чиглэгдсэн ба сонгуультай шууд буюу шууд бусаар холбогдуулан сонгуулийн зардлын данснаас гаргалгүйгээр их хэмжээгээр хэрэгжүүлсэн төлбөртэй ажил гүйцэтгэсэн, бараа борлуулсан, төлбөртэй үйлчилгээ үзүүлсэн, үндэслэлгүйгээр бууруулсан үнээр сонгуулийн зардлын данснаас төлбөр хийсэн бол хоёр зуун мянгаас таван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл гурван зуун жаран цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл мөн хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Сонгуулийн зардлын данснаас гадуур сонгуульд нэр дэвшигч, тухайн нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, шадар туслагч сонгуульд нэр дэвшигчийг дэмжүүлэхийн тулд их хэмжээний хөрөнгө мөнгө ашигласан, түүнчлэн сонгуулийн ба ард нийтийн санал асуулгын тухай хууль тогтоомжоор хориглосон ба сонгуулийн зардлын данс, ард нийтийн санал асуулгын зардлын дансанд байгаагаас илүү хэмжээний мөнгөн хөрөнгийг зарцуулсан бол хоёр зуун мянгаас таван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл нэгээс таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эсхүл дөрвөн зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

142 дугаар зүйл. Сонгуулийн баримт бичиг, бүх нийтийн санал асуулга явуулах баримт бичиг хуурамчаар үйлдэх.

1. Хэрэв сонгуулийн хороо, ард нийтийн санал асуулга явуулах хорооны гишүүн, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, шадар туслагч сонгуулийн баримт бичиг, ард нийтийн санал асуулгын баримт бичгийг хуурамчаар үйлдсэн бол нэг зуун мянгаас гурван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны хоёр жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл мөн хугацаагаар хорих яд шийтгэнэ.
2. Урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл худалдан авч, хууран мэхэлж, хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж, түүнчлэн эд хөрөнгө устгаж буюу түүнийг устгахаар айлган сүрдүүлж, эсхүл иргэн буюу байгууллагын эрх ба хууль ёсны ашиг сонирхол буюу нийгэм төрийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг ноцтой зөрчиж сонгогчдыг тэмдэглэгээг хуурамчаар үйлдсэн бол хоёр зуун мянгаас таван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл тодорхой албан тушаал эрхлэх тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хоёроос таван жил хүртэл хугацаагаар хасах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл мөн хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Сонгуулийн хуудас, ард нийтийн санал асуулгын хуудсыг хууль бусаар бэлтгэсэн, түүнчлэн түүнийг хадгалсан, тээвэрлэсэн бол хоёр зуун мянгаас

таван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хоёроос таван жил хүртэл хугацаагаар хасах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх эсхүл мөн хугацаагаар хорих ял шийтгэнэ.

142.1 дүгээр зүйл. Сонгуулийн үр дүнг хуурамчаар үйлдэх

Санал авахад зарцуулсан саналын хуудасны тоонд зарцуулаагүй саналын хуудас оруулсан, эсхүл сонгогчид ард нийтийн санал асуулгад оролцогчийн тухай буруу мэдээ сэлтийг зориуд өгсөн, эсхүл сонгох эрхгүй буюу ард нийтийн санал асуулгад оролцох эрхгүй этгээд буюу зохиомол нэр бүхий этгээдийг оруулан сонгогчид, ард нийтийн санал асуулгад оролцогчдын нэрсийн жагсаалтыг зориуд буруу бүрдүүлсэн, эсхүл сонгогчид, ард нийтийн санал асуулгад оролцогчдын тэмдэглэгээг хуурмагласан, эсхүл саналын хуудсыг сонгогчдын хүсэл зоригийг тодорхойлох боломжгүй болгосон, эсхүл саналын хуудсыг хууль бусаар устгасан, эсхүл сонгогчид, ард нийтийн санал асуулгад оролцогчдын саналыг зориуд буруу тоолсон, эсхүл сонгуулийн хорооны гишүүд санал тоолохоос өмнө санал хураалтын үр дүнгийн тухай буюу санал хураалтын үр дүнг тогтоох протоколд гарын үсэг зурсан, эсхүл санал хураалтын үр дүнгийн тухай буруу шийдвэр, тэмдэглэлийг зориуд үйлдсэн, эсхүл санал хураалтын үр дүнгийн тухай шийдвэрт түүнийг үйлдсэний дараа хууль бус өөрчлөлт оруулсан, эсхүл санал хураалтын үр дүн, сонгууль, ард нийтийн дүнг зориуд буруу тодорхойлсон болон хоёр зуун мянгаас таван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл мөн хугацаагаар хорих ял шийтгэнэ.

142.2 дугаар зүйл. Бүх нийтийн санал асуулгын саналын хуудсыг хууль бус гаргах, хүлээн авах

1. Сонгуулийн комиссын гишүүн, бүх нийтийн санал асуулга явуулах комиссын гишүүн нь сонгуулийн санал хураалтад оролцогч, бусад сонгогч, ард нийтийн саналд оролцогчдын өмнөөс санал өгөх, эсхүл хоёроос дээш удаа санал өгөх боломжийг олгох зорилгоор саналын хуудас нэмж хуудас олгох, эсвэл иргэдэд өмнө бөглөсөн саналын хуудас өгсөн болон таван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны арван найман сараас гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл мөн хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Сонгогч эсвэл санал өгөгчийн өмнөөс санал өгүүлэх зорилгоор саналын хуудас нэмж өгсөн, бөглөсөн саналын хуудас өгсөн, хоёр болон түүнээс дээш удаа дахин санал өгсөн хуудсыг сонгуулийн комисс, санал асуулгын комисс хүлээж авсан бол нэг зуун мянгаас гурван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл мөн хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ зүйлийн нэг болон хоёр дах хэсэгт заасан хэргийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол дөрвөн зуун мянгаас долоон зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны хоёроос дөрвөн жилийн хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл дөрвөн зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

III. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хууль тогтоомж дах зохицуулалт:

ЭХ-ийн VII бүлэгт, Төрийн албан тушаалтан үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой гэмт хэргүүд

128 дугаар зүйл. Сонгуульд саад учруулах: Хууль тогтоомжид заасны дагуу сонгуульд сонгогч, нэр дэвшигч, нэр дэвшихээр зорьж буй хүнийг айлган сүрдүүлж, сонгуулийн эрх, эрх чөлөөнд өөр ямар нэг байдлаар саад учруулсан, прокурор, цагдаа, цэргийн үүрэг бүхий төрийн албан тушаалтанд 10 жилээс доошгүй хугацаагаар хорих, таван жилээс доошгүй хугацаагаар эрх хасах ял шийтгэнэ.

134 дүгээр зүйл. Хөрөнгө орлогыг албадан хураах, цуглуулах: Гэмт хэрэгтэн, эсхүл үүнд оролцогч гуравдагч этгээдийн авсан авлига, мөнгө, эд хөрөнгийг хурааж, хэрэв хураах боломжгүй бол түүний үнийн дүнг хураан авна.

135 дугаар зүйл. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмт хэрэг үйлдсэн бол ял хүндрүүлэх: Албан тушаалын бүрэн эрхээ ашиглаж энэ бүлэгт зааснаас бусад гэмт хэрэг үйлдсэн төрийн албан тушаалтны үйлдсэн гэмт хэрэгт, заасан ялын -тэй тэнцэх ял оногдуулна. Үүнд, төрийн албан тушаалтны эрхэлж буй ажлын нөхцөл байдлаас шалтгаалж үйлдсэн гэмт хэрэгт, ялыг тусгайлан заасан тохиолдолд хамаарахгүй.

ISBN 991991363-4



9 789919 913632